

**ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ:  
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Б.Буянзаяа, Г.Билгээ П.Уранчимэг,  
Ц.Ариунаа, Б.Туул*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ:  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- 1.Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго
- 2.Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо
- 3.Зөвшөөрлийн нэр төрөл, тоог тогтоох, өөрчлөлт оруулах процедур
- 4.Зөвшөөрлийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо ба эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын зарим орнуудад олгодог зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн төрөл, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн жагсаалтад өөрчлөлт оруулах, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-д хяналт тавих механизм зэрэг асуудлуудыг эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судаллаа.

Судалгаанд дараах орнуудыг хамруулсан:

- Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ);
- Шотланд Улс;
- Сингапур Улс;
- Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг (ТУХН)-ийн улсууд:
  - Азербайжан Улс;
  - Армени Улс;
  - Гүрж Улс;
  - Казахстан Улс;
  - Киргиз Улс;
  - ОХУ;
  - Узбекистан Улс.

### **Судалгааны хамрах хүрээ:**

Судалгаанд авагдсан орнуудын холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) эрхлэх үйл ажиллагааны зохицуулалтад хамаарах асуудлуудыг доорх хүрээнд судаллаа. Үүнд:

- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо буюу арга механизмын талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, санал, дүгнэлт гаргах болон хяналт тавих чиг үүрэг бүхий зохион байгуулалтын бүтэц (тухайлбал, Олон нийтийн зөвлөл)-ийн эрх зүйн байдал, бүтэц бүрэлдэхүүн, санхүүжилтийн талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоо буюу төрлүүдийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох гэх мэт асуудлуудыг хамруулсан.

**Түлхүүр үг:** тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лицензийн зөвлөл, лиценз, лиценз олгох, лицензтэй эрхлэх үйл ажиллагаа, зөвшөөрөл болон лицензийн систем, лицензийн комисс

**Key words:** licences, permits, licensing-board.

**Ключевые слова:** лицензия, лицензирования, лицензируемый вид деятельности, разрешение, система лицензий и разрешений, лицензионный совет, лицензионный комиссия.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Оксфордын англи хэлний толь бичигт “**тусгай зөвшөөрөл**” (licence) гэж “эрх бүхий байгууллагаас хэн нэгэнд олгосон ямар нэгэн зүйлийг хийх, өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл” гэж тодорхойлсон бол “**зөвшөөрөл**” (permission) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг албан ёсоор зөвшөөрөх ажиллагаа, эсхүл эрх олгосон албан ёсны баримт бичиг” хэмээн тайлбарласан.

Түүнчлэн Кембрижийн толь бичигт “**тусгай зөвшөөрөл**” (license) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйлийг хийх болон эзэмших эрх буюу албан ёсны зөвшөөрөл олгох” гэж тайлбарласан бол “**зөвшөөрөл**” (permission) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг зөвшөөрөх, эсхүл ямар нэгэн зүйл тохиолдохыг зөвшөөрсөн баримт бичиг” хэмээн тус тус тайлбарлажээ.

Хэл зүйн тайлбар талаас нь үзвэл “тусгай зөвшөөрөл” гэдэг нь аливаа үйл ажиллагаа явуулах, өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон өргөн цар хүрээтэй үйлдэл бол “зөвшөөрөл” гэдэг нь зөвхөн аливаа зүйлийг хийх зөвшөөрөл олгох үйлдэл буюу үүнийг гэрчилсэн баримт бичиг хэмээн ойлгогдож байна. Тиймээс хууль зүйн нэр томъёо талаас нь “тусгай зөвшөөрөл” болон “зөвшөөрөл”-ийн ялгаа, заагийг тодорхой болгох нь хуулийн зохицуулалт талаасаа ч, хэрэглээнд хэвшүүлэх талаасаа ч чухал ач холбогдолтой хэмээн үзэж дээрх тайлбарыг авч үзсэн болно.

Улс орнуудын хувьд, тухайлбал, Канад Улсад “тусгай зөвшөөрөл” (licence) нь тухайн үйл ажиллагааг эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны нарийвчилсан стандарт шаардлагыг тодорхойлдог бол “зөвшөөрөл” (permission, permit) нь ерөнхий шинжтэй байна. Жишээлбэл, архины худалдаа эрхлэхэд “зөвшөөрөл” авдаг бол архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхэд “тусгай зөвшөөрөл” авах шаардлагатай болдог байна.

Монгол Улсын хувьд 2021 онд Хууль зүйн яамнаас эмхэтгэн гаргасан Монгол Улсын “Хууль зүйн нэвтэрхий толь бичиг”-т “**тусгай зөвшөөрөл**” (licentia; license<sup>1</sup>) гэж “тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичиг” гэж томъёолсон бөгөөд тус толь бичигт “**зөвшөөрөл**”-ийн талаарх хууль зүйн нэр томъёоны тайлбар одоогоор байхгүй байна.

Иймд Зөвшөөрлийн тухай хуулийн нэгтгэсэн төсөлд “тусгай зөвшөөрөл”, “зөвшөөрөл”-ийн ялгаа зааг, хамрах хүрээ, хууль зүйн тайлбарыг нэр томъёоны хувьд илүү нарийвчлах нь зүйтэй болов уу.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг хурангуйлан авч үзвэл:

### 1. Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго

Судалгаанд нийт 10 орныг хамруулсан. Захиалагчийн хүсэлтэд нийцүүлэн ихэвчлэн бие даасан хуультай орнуудыг сонгон авч судалсан бөгөөд Сингапур Улсаас бусад нь зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай бие даасан хуультай орнууд байна. Эрх зүйн орчны хүрээг авч үзвэл эдгээр орнуудад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг тусгайлсан хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам болон холбогдох салбарын хуулиудаар зохицуулж байна.

Судалгаанд авагдсан орнуудад зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг дараах бие даасан хуулиудаар зохицуулж байна:

<sup>1</sup> Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 424 дэх тал.

- 1.Азербайжан *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль (Закон О лицензиях и разрешениях);*
- 2.Армени *Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль (Закон О лицензировании);*
- 3.Гүрж *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль (Закон О лицензиях и разрешениях);*
- 4.Казахстан **Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль (Закон О разрешениях и уведомлениях);**
- 5.Киргиз *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хууль (Закон О лицензионно-разрешительной системе);*
- 6.ОХУ *Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хууль (Закон О лицензировании отдельных видов деятельности);*
- 7.Узбекистан *Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хууль (Закон О лицензировании, разрешительных и уведомительных процедурах);*
- 8.БНХАУ *Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль (Administrative License Law of the People's Republic of China);*
- 9.Шотланд *Тусгай зөвшөөрлийн тухай хууль (Licensing (Scotland) Act 2005);*
- 10.Сингапур Тусгайлсан хуулиар зохицуулаагүй.

Эдгээр хуулиудын зорилго нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, үндэстэн болон олон нийтэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахын зэрэгцээ хязгаарлагдмал нөөцийг зохистой ашиглах, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой зарим үйл ажиллагаа, үйлдэлд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгодог байх нийтлэг зорилгод чиглэгдсэн.

Дээрх хуулиудаар зохицуулсан харилцааны зорилго, цар хүрээг багцлан авч үзвэл:

- хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийт, төрийн аюулгүй байдалд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх болон хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглуулах;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-өөр зохицуулагдах хүрээг тодорхойлох;
- хувиараа аж ахуй эрхлэгчид болон бусад этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг тодорхойлох;
- тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих процедур, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн ангилал, төрлүүд болон холбогдох бусад харилцааг зохицуулахад чиглэгдсэн байна.

Судалгаанаас үзэхэд, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахаас гадна тухайн салбарын эрх зүйн орчны хүрээнд нарийвчлан зохицуулж байна. Тухайлбал, **Армени Улсад** эрчим хүч, цахим харилцаа холбоо, усны салбарын тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай, Цахим харилцаа холбооны тухай, Телевиз, радиогийн тухай хуулиуд болон Усны тухай кодексоор, **Азербайжан Улсад** зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг Аж ахуйн нэгжийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор, **Киргиз Улсад** банк санхүүгийн тусгай зөвшөөрлийг банкны тухай хууль тогтоомжоор, **Гүрж, ОХУ**-д ашигт малтмал олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Газрын хэвлийн тухай хуулиар, **Шотланд Улсад** театрын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Театрын тухай хуулиар, кино театрын тусгай зөвшөөрлийг Кино театрын тухай хуулиар тус тус зохицуулах жишээтэй.

**Сингапур Улсад** зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой бие даасан хууль байхгүй бөгөөд уг харилцааг салбарын хуулиудаар зохицуулж байна. Тухайлбал, банкны тусгай зөвшөөрлийг *Банкны тухай* хуулиар, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг *Барилгын хяналтын тухай* хуулиар, даатгалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг *Даатгалын тухай* хуулиар, цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрлийг *Цахилгаан, эрчим хүчний тухай* хуулиар, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хуулиар гэх мэтээр зохицуулж байна.

**2.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо:**

Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудад буюу Армени, Гүрж, Киргиз, ОХУ, Узбекистан, БНХАУ, Сингапур, Шотландад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд түүнийг **олгож буй эрх бүхий байгууллага** хяналт тавьж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагууд шаталсан, хавсарсан байдлаар хяналт тавих бөгөөд төрийн болон олон нийтийн хяналтыг хослуулан улс орон бүр өөр өөрийн онцлогт нийцүүлэн хяналтын тогтолцоогоо бүрдүүлсэн байна. Түүнчлэн зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгох, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах цахим систем, платформуудыг хөгжүүлэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал:

**Казахстанд** аливаа зөвшөөрөлд төрийн хяналт тавих эрх бүхий байгууллагууд болон **орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд, Азербайжанд** зөвшөөрөл олгосон байгууллагууд болон төрийн хяналт тавих эрх бүхий байгууллагууд хяналтыг хамтран хэрэгжүүлж байна.

Судалгааны захиалгад зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлтэй холбоотой зохицуулалтын талаар дурдсан байв.

Үүний дагуу гадаадын 13 улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай хууль тогтоомжийг судалж үзэхэд **Шотланд Улсад** дээрхтэй төстэй зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. Тус улсын тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг боловсруулах эрх, үүрэгтэй **Абердиний Лицензийн зөвлөл** ажилладаг байна. Зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй бөгөөд энэхүү эрхээ орон нутагт лицензийн стандарт хариуцсан ажилтнуудыг томилон ажиллуулж хэрэгжүүлдэг. Абердиний Лицензийн зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй. Тус зөвлөл нь 12 хороотой<sup>2</sup> ба хороо тус бүр өөрийн хариуцсан асуудлын хүрээнд салбарын асуудлыг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргах боломжоор хангагдсан байдаг. Тухайлбал, *Лицензийн хороо* нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх асуудлыг хариуцан ажилладаг. *Аудит, эрсдэл, хяналтын хороо* нь дотоод, гадаад аудит, эрсдэлийн удирдлага, засаглал, санхүүгийн асуудлаас гадна хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх эрхтэй.

**БНХАУ**-д тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавьж үнэлэлт өгөх боловч захиргааны дээд шатны байгууллага нь тухайн эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаа, захиргааны

<sup>2</sup> Энэ тайлангийн 15-р хуудас

тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог улам чангатгах хэлбэрээр ажилладаг бөгөөд гарсан хууль бус үйлдлийг цаг тухайд нь арилган ажилладаг байна. Түүнээс гадна захиргааны тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж гарсан санал, дүгнэлтээ тусгай зөвшөөрлийг тогтоох эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажилладаг Захиргааны тусгай зөвшөөрлийн гүйцэтгэх байгууллага ажилладаг байна.

**Сингапур Улсад** зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг холбогдох салбарын хууль, түүнийг даган гарсан журмаар зохицуулдаг тул зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд тавих хяналтыг тухайн зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгосон байгууллага нь хэрэгжүүлдэг байна. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг Сингапур Улсын Засгийн газрын холбогдох агентлагууд олгох ба зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) авахаас өмнө Засгийн газрын бүртгэлийн агентлаг болох Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах газарт заавал бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд бүртгүүлэхдээ зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) авах хүсэлтээ цуг гаргаж болдог. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг Засгийн газрын цахим үйлчилгээний платформ болох <https://www.gobusiness.gov.sg> цахим хуудсаар дамжуулан олгох, олон нийтэд мэдээлэл хүргэх, ил тод нээлттэй байдлыг хангах онцлогтой байна.

Тусгаар Улсын хамтын Нийгэмлэгийн (ТУХН)-ийн ихэнх орнуудад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилт, тухайн зөвшөөрөлд тавигдах нөхцөл, тусгай шаардлагын биелэлтэд тухайн зөвшөөрлийг олгосон байгууллагууд хяналт тавьж байна.

**Арменид** Төв Банк, Төрийн үйлчилгээний зохицуулах хороо, Телевиз, радиогийн үндэсний хороо, Засгийн газраас эрх олгосон яам, агентлагууд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгодог. Эдгээр байгууллагууд нь **Тусгай зөвшөөрлийн хороо** (ТЗХ)-г байгуулах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлахад тус хорооны дүгнэлтийг үндэслэнэ.

ТЗХ нь өргөдөл гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг хорооны хурлаараа хэлэлцэж дүгнэлт гаргах ба энэхүү дүгнэлтээ тусгай зөвшөөрөл олгох байгууллагын даргад шилжүүлнэ.

Тухайлбал, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий **Телевиз, радиогийн үндэсний хороо** (ТРҮХ) нь телевиз, радиогийн хувийн хэвшлийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийн биелэлт болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, үүрэгтэй. ТРҮХ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Ерөнхийлөгчөөс зургаан жилийн хугацаагаар томилно. Тус хорооны дарга, дэд даргыг гишүүдээсээ сонгоно.

**Азербайжан Улсад** холбогдох тусгай зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-д тавих хяналтыг тухайн зөвшөөрөл олгох салбарын эрх бүхий байгууллага болон хуулиар эрх олгосон төрийн эрх бүхий байгууллага гэсэн 2 субъект хэрэгжүүлдэг байна. Төрийн эрх бүхий байгууллага нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны зөвшөөрлүүдэд, харин зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгох салбарын байгууллагууд нь салбарын хуулиар олгож байгаа зөвшөөрлүүдэд тус тус хяналт тавина.

**Киргизэд** зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгогч байгууллага нь хууль, Сайд нарын танхимаас баталсан “Зарим төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай журам”-аар тогтоосон тусгай зөвшөөрлийн шаардлагыг тухайн зөвшөөрөл эзэмшигч хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийдэг. Хяналт шалгалтыг дараах байдлаар зохион байгуулдаг. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгохоос өмнөх шалгалт;
- тусгай зөвшөөрөл олгосны дараах шалгалт;

- төлөвлөгөөт бус шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авах, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл хүлээн авсны дараа тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас хийдэг шалгалт, мөн өмнөх шалгалтаар илрүүлсэн тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавих шалгалт;
- төлөвлөгөөт шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу хийдэг шалгалт юм.

**ОХУ-д зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хяналтыг зохион байгуулахдаа Төрийн болон хотын хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэх, Хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан журмыг баримталдаг** байна. Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа мөн төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус шалгалт хэлбэрээр хийдэг бөгөөд энэхүү шалгалтын зохион байгуулалтын хэлбэр нь дээр дурдсан Киргиз Улстай ижил байна.

**Узбекистанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгогч байгууллага хяналт шалгалтын ажлыг зохион байгуулдаг бөгөөд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн болон мэдэгдлийн шаардлага, нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг:**

- тусгай цахим системээр дамжуулан зайнаас шалгах;
- хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу газар дээр нь очиж шалгах;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл), мэдэгдлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон тэднээс шаардлагатай мэдээллээ хүсэх зэргээр хэрэгжүүлдэг бөгөөд холбогдох этгээдээс хамааралгүй мэдээлэл хүсэх, шаардахыг хориглодог байна.

Казахстанд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд тавих хяналтыг төрийн эрх бүхий байгууллагууд болон орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд хэрэгжүүлнэ. Тус улсад Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийн хяналтыг:

- аливаа зөвшөөрлийг олгохоос өмнө букуу өргөдөл гаргагчийн тухайн зөвшөөрлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд,
- аливаа зөвшөөрлийг олгосны дараа тухайн зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг байна. Зөвшөөрөл олгохоос өмнөх хяналтыг тухайн субъект (объект) дээр очиж шалган тогтоодог байна.

### **3.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоог тогтоох, жагсаалтад өөрчлөлт оруулах процедур:**

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоог тогтоох, өөрчлөлт оруулах эрх зүйн харилцааг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулдаг (БНХАУ, Азербайжан, Армени, Гүрж, Казакстан, Киргиз, ОХУ, Узбекистан) байна. Харин зарим орнуудын хувьд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) **олгох эрх бүхий** төрийн захиргааны байгууллага (Сингапур) нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, өөрчлөх, сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэдэг бол зарим улс оронд Засгийн газрын тодорхой бодлогын асуудлуудыг хариуцан зохицуулах үүрэг бүхий орон тооны зөвлөл (Шотланд) ажилладаг байна. Мөн зарим улсад (БНХАУ) хэдийгээр зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн **харилцааг хуулиар тогтоосон байдаг ч шаардлагатай тохиолдолд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд захиргааны зөвшөөрөл олгож болох эрх зүйн зохицуулалтыг ч мөн адил хуульд тусгаж өгснөөрөө онцлогтой байна.**



Тухайлбал, **БНХАУ-д** Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоохоор заасан байдаг боловч шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг захиргааны журмаар (Төрийн зөвлөлийн шийдвэр, захиргааны журам, мужийн түвшний Ардын засгийн газрын тогтоолууд хамаарна) тогтоож болохоор тус хуульд зааж өгсөн байдаг.

Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоох<sup>3</sup> дараах 6 үндэслэлийг заасан байдаг. Үүнд:

- улсын болон олон нийтийн аюулгүй байдал, экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдалтай шууд холбоотой тусгай үйл ажиллагааг хуулийн шаардлагад нийцүүлэн батална;
- байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх;
- төрөөс үйлчилгээ үзүүлдэг, нийтийн ашиг сонирхол шууд хамааралтай, тусгай ур чадвар, тусгай нөхцөл шаардсан мэргэжлүүд;
- орчин тойрондоо аюул учруулж болзошгүй тоног төхөөрөмж, барилга байгууламж, бүтээгдэхүүн, эд зүйлсийг стандарт, шалгуурын дагуу үзлэг, туршилт, хорио цээрийн аргаар шалгаж баталгаажуулсан байх;
- мэргэшлийн түвшин тогтоож тусгай зөвшөөрөл олгох байгууллага байгуулах;
- хууль тогтоомжийн дагуу захиргааны тусгай зөвшөөрөл олгож болох бусад асуудлууд.

Хэдийгээр Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоохоор заасан ч хуулийн 14 дүгээр зүйлд шаардлагатай тохиолдолд Төрийн зөвлөл тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж болох эрхтэй байхаар заасан байна.

Мөн Захиргааны тусгай зөвшөөрлийн талаарх хууль, захиргааны журам хараахан гараагүй ч нэн даруй тусгай зөвшөөрөл тогтоох шаардлага гарсан бол тус хуулийн 12 дугаар зүйлд заасан асуудлын хүрээнд тусгай зөвшөөрлийг орон нутаг захиргааны журмаар тогтоож болохоор хуульчилжээ. Ингэхдээ тухайн аймгийн Ардын засгийн газрын журмаар автономит муж, эсхүл төв Засгийн газрын шууд харьяа хотын захиргаа нь захиргааны түр тусгай зөвшөөрлийг олгох эрхтэй байх бөгөөд уг түр тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгож, хугацааг сунгах шаардлагатай бол Ардын их хурал, түүний Байнгын хороонд анх олгосон байгууллага санал гаргаж шийдвэрлүүлнэгэж заасан байна.<sup>4</sup>

**Шотланд Улсын** Абердиний Лицензийн зөвлөл нь тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал дүгнэлтийг боловсруулдаг.

Энэхүү зөвлөл нь 2005 онд батлагдсан Тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан "тусгай зөвшөөрөл олгох" дээд түвшний 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагааны бодлогыг боловсруулан ажиллах эрхийг хуулиар өгсөн байна.

Эдгээр 5 зорилго нь:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Олон нийтийн таагүй байдлаас урьдчилан сэргийлэх;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах; болон
- Хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах гэх мэт.

**Сингапур Улс** нь бие даасан хуульгүй учраас салбарын хууль, түүнийг дагаж гарсан журмаар зохицуулдаг байна. Тухайлбал, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Засгийн

<sup>3</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 12 дугаар зүйл

<sup>4</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 15 дугаар зүйл



газрын агентлаг болон Анагаах ухааны газар олгох бөгөөд Тамхины тухай хууль, түүнийг дагаж гарсан Тамхины (зар сурталчилгаа, борлуулалтын хяналт, тусгай зөвшөөрөл олгох) журамд заасан нөхцөл шаардлагын дагуу олгох, өөрчлөх, сунгах, цуцлах, хүчингүй болгох шийдвэрийг гаргана.

**Армени, Гүрж, Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистан** улсуудад тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг хуульд тодорхой жагсааж хуульчилжээ. Ийнхүү хуулиар тогтоосон байгаа нь зөвхөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг жагсаалтыг өөрчлөх боломжтойг харуулж байна.

Эдгээр улсууд жагсаалтад өөрчлөлт оруулах шалгуурууд тогтоосон байх тул тэдгээрийг дараах байдлаар багцаллаа. Үүнд:

- эдийн засгийн хөгжлийг дэмжих;
- хүний ба иргэний амь нас, эрүүл мэндэд, хүний амьдрах болон соёлын орчинд хохирол учруулахгүй байх;
- хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх;
- үндэсний болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах зэрэг болж байна.

**ОХУ**-д 2014 оноос орон сууцны барилга барих тусгай зөвшөөрлийг, 2018 оноос биоанагаахын эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, амьтны хүрээлэн, цирк, усан сан зэрэг зориулалтын газарт амьтдыг арчлах, ашиглах зэрэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус шинээр олгож эхэлжээ. Цаашид ч техник, технологи хөгжихийн хэрээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны жагсаалтыг өргөжүүлэх шаардлага гарч ирж байна. Жишээлбэл, криптовалюта, блокчэйнийг дурдаж болно.

#### **4.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох:**

Судалгаанд хамрагдсан улс орнуудад (Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан, БНХАУ) сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаа зэрэг өрсөлдөөний аргаар зохион байгуулахаар эрх зүйн хувьд хуульчилсан бол зарим улс орнуудад эрх зүйн бусад актаар энэхүү асуудлыг зохицуулж өгсөн байна.

Тухайлбал, **БНХАУ**-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд сонгон шалгаруулалт, дуудлага худалдаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

Тус хуулийн 53 дугаар зүйлд зааснаар Захиргааны байгууллага байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо тендер, дуудлага худалдаа зэрэг шударга өрсөлдөөний аргыг хэрэглэн шийдвэр гаргадаг байна.

Тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаагаар олгох журам нь холбогдох хуульд нийцсэн байх шаардлагыг хуулиар тавьж өгсөн бөгөөд журмын дагуу тендерт ялагч, худалдан авагчийг тодруулсны дараа ялагчид тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгодог.

Захиргааны байгууллага нь Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийг зөрчиж тендер, дуудлага худалдааны хэлбэрийг батлаагүй байх, эсхүл тендер, дуудлага худалдаа явуулах журмыг зөрчсөн нь өргөдөл гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд өргөдөл гаргагч нь хуулийн дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй хэмээн хуульчилжээ.

Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн харилцааг зохицуулж байгаа бие даасан хуулиудад тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгож болохоор хуульчилсан.

**Гүрж Улсын** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар энэ асуудлыг илүү тодорхой зохицуулжээ. Харин **ОХУ**-ын Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгох харилцааг зохицуулаагүй байна. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах нийтлэг журмыг Газрын хэвлийн тухай хуулиар, нарийвчилсан харилцааг Холбооны улсын Газрын хэвлий ашиглалтын агентлаг (Роснедр)-ийн регламентаар тус тус зохицуулсан байна. **Узбекистанд** тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-ын үндсэн дээр олгох бөгөөд түүнийг сонгон шалгаруулалт (тендер)-аар олгох журам, нөхцөлийг тус улсын Сайд нарын танхим тогтооно.

**Гүрж** болон **ОХУ**-д хуулиар тогтоосон, эсхүл тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тавьсан нөхцөл, шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөл хүсэгч бүхэн дуудлага худалдаанд оролцох эрхтэй. ОХУ-д газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд ялагчийг тодруулахад тухайн оролцогчийн шинжлэх ухаан, техникийн түвшин, тухайн бүс нутагт ажилласан туршлага, тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, мөн газрын хэвлий ашиглах эрхийн нэг удаагийн төлбөрийн хэмжээ зэргийг гол шалгуураа болгодог.

**Сингапур, Шотланд** улсуудын холбогдох хууль тогтоомж, түүнийг даган гарсан журмын хүрээнд мэдээллийн хайлт хийж үзэхэд дуудлага худалдаа болон сонгон шалгаруулалтаар олгож байгаа зохицуулалт байхгүй байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

#### 1.Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго

**Бүгд Найрамдах Хятад Ард Улс** (БНХАУ)-д зөвшөөрөлтэй холбоотой харилцааг бие даасан хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад журмаар зохицуулдаг. Үүнд:

- БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль;<sup>5</sup>
- Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийн тайлбар;<sup>6</sup>
- Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол.<sup>7</sup>

**БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль**<sup>8</sup> (Administrative License Law of the People's Republic of China) 2003 онд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Байнгын хорооны IV хуралдаанаар баталсан, 8 бүлэг 83 зүйлтэй хууль юм.

**Хуулийн зорилго:** Хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны тусгай зөвшөөрөл тогтоох, олгох, хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах, иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагын хууль ёсны эрх, ашгийг хамгаалах, нийтийн ашиг сонирхол, нийгмийн хэв

<sup>5</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль.

<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>

<sup>6</sup> БНХАУ-ын захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-ийн тайлбар.<http://xzspj.nc.gov.cn/ncspj/zcjd/201912/4151afa2a3f1463eaab35ee76e7b792b.shtml>

<sup>7</sup> Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол. [http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content\\_1228.htm](http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content_1228.htm)

<sup>8</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль.

<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>

журмыг хамгаалах, захиргааны удирдлагын хэрэгжилтийг хангах, хяналт тавих зорилготой” гэж заасан байна.

**Захиргааны тусгай зөвшөөрөл** гэж “захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагад өргөдлийн дагуу тусгай үйл ажиллагаа эрхлэхийг хуульд заасан журмын дагуу зөвшөөрч буй үйлдлийг хэлнэ” хэмээн уг хуулийн 2 дугаар зүйлд хуульчилсан байна.

Хятадын Төрийн зөвлөлөөс 2022 онд захиргааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх асуудлыг нэгтгэн журамлах зорилгоор “Захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтыг улс орон даяар нэгтгэн нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг цогцоор нь судалж, дүгнэн ажиллахаар шийдвэрлэсэн. Ингэхдээ бүх шатны захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтад тусгай зөвшөөрлийн нэр, хариуцсан хэлтэс, хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжилтийн үндэслэл, хэрэгжүүлэх протоколыг жагсаалтын зүйл тус бүрээр нэг бүрчлэн зааж өгөх бөгөөд энэхүү ажлын хүрээнд дараах өөрчлөлтүүдийг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. ижил төрлийн тусгай зөвшөөрлүүдийг өөр бүс нутагт ижил стандартаар хэрэгжүүлэх;
2. орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний тоо, зориулалт нь дээд шатны байгууллагаас баталсан тусгай зөвшөөрлийн жагсаалтаас хэтрэхгүй байх;<sup>9</sup>
3. тусгай зөвшөөрлийн шаардлага, өргөдлийн материал, батлах журам, хураамжийн хэмжээг тодорхой тогтоож, нийтэд мэдээлэх бөгөөд хэрэгжүүлэх явцад нэмэлт нөхцөл, хязгаарлалт тавихгүй байх.

Энэхүү арга хэмжээний үр дүнд:

Засгийн газар, эрх бүхий байгууллагууд захиргааны тусгай зөвшөөрлийг хэрэгжүүлэхдээ жагсаалтыг чанд мөрдөж зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох.

Хууль тогтоомжид заасан хяналт шалгалтыг эрчимжүүлснээр жагсаалтад байгаа захиргааны тусгай зөвшөөрлийн зүйл бүрийн дор харьяалах хяналтын байгууллагууд, гол холбоосууд, дүрэм, стандартуудыг зааж өгөх бөгөөд ингэснээр нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй шууд холбоотой, эсхүл томоохон эрсдэлтэй газруудад хяналт тавихад тэргүүлэх ач холбогдолтой болох юм.

Тусгай зөвшөөрөл олгох, түүнтэй холбоотой хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг нэг цэгээр онлайн байдлаар хэрэгжүүлэх бөгөөд аж ахуйн нэгж, иргэдэд төрийн үйлчилгээг хялбар хүртээмжтэй болгоно.<sup>10</sup>

БНХАУ-ын Төрийн зөвлөл “Захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтыг хатуу батлан хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдээс дээрх жагсаалтаас гадуурх зөвшөөрөл шаардахгүй байх, ингэснээр нээлттэй, ил тод орчинд ижил тэгш өрсөлдөөнийг бий болгохыг зорьж ажиллаж байна.”<sup>11</sup>

**Шотланд Улсад** тусгай зөвшөөрөл (лиценз) болон зөвшөөрөлтэй холбоотой үндсэн харилцааг 2005 онд батлагдсан **Тусгай зөвшөөрлийн тухай хуулиар**<sup>12</sup> Licensing Act Scotland зохицуулахаас гадна аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Тухайлбал, орон сууцны бүртгэл - Орон сууцны тухай хууль, хувийн орон сууц эзэмшигчийн бүртгэл - Нийгмийн эсрэг зан үйлийн тухай хууль, театрын лиценз - Театрын тухай хууль, кино театрын лиценз

<sup>9</sup> БНХАУ-ын Төрийн зөвлөлийн цахим хуудас.

<sup>10</sup> [http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content\\_WS61f64f28c6d09c94e48a4906.html](http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content_WS61f64f28c6d09c94e48a4906.html)

<sup>11</sup> [http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content\\_WS61d4d454c6d09c94e48a3213.html](http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content_WS61d4d454c6d09c94e48a3213.html)

<sup>12</sup> [http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content\\_WS61d4d454c6d09c94e48a3213.html](http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content_WS61d4d454c6d09c94e48a3213.html)

<sup>12</sup> <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-scotland-act-2005>

- Кино театрын тухай хууль, спортын талбайн аюулгүй байдал - Спортын талбайн аюулгүй байдлын тухай хууль.

**Сингапур Улсад** аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Тухайлбал, банкны тусгай зөвшөөрлийг Банкны тухай хуулиар, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын хяналтын тухай хуулиар, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Даатгалын тухай хуулиар, цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрлийг Цахилгаан, эрчим хүчний тухай хуулиар, Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл авахаас өмнө Засгийн газрын бүртгэлийн агентлаг болох Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах газар<sup>13</sup> (Accounting and Corporate Regulatory Authority - ACRA)-т бүртгүүлсэн байх шаардлагатай. Тус газар нь бизнесийн үйл ажиллагааны бүртгэл болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийг хариуцдаг.<sup>14</sup>

Хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд буюу **Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл** (ТУХН)-ийн гишүүн зарим улсад бие даасан дараах хуулиудаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үүнд:

- 1.Азербайжан Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль<sup>15</sup> (2016);
- 2.Армени Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль<sup>16</sup> (2001);
- 3.Гүрж Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль<sup>17</sup> (2005);
- 4.Казахстан **Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль**<sup>18</sup> (2014);
- 5.Киргиз Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хууль<sup>19</sup> (2005);
- 6.ОХУ Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хууль<sup>20</sup> (2011);
- 7.Узбекистан Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хууль<sup>21</sup> (2021).

Дээрх бие даасан хуулиудын зорилго, зохицуулах харилцааг багцлан авч үзвэл:

- хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийт, төрийн аюулгүй байдалд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх болон төрийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглах (Гүрж, Киргиз);
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-өөр зохицуулагдах харилцааны хүрээг тодорхойлох (Азербайжан, Гүрж);
- тодорхой үйл ажиллагааны төрөлд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг тогтоох (Азербайжан, Армени, Гүрж, Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистан);

<sup>13</sup> Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах тухай хууль (Accounting and Corporate Regulatory Authority Act, 2004)-ийн 1 бүлгийн 2.1 дэх зүйл. <https://sso.agc.gov.sg/Act/ACRAA2004>

<sup>14</sup> <https://www.acra.gov.sg>

<sup>15</sup> Закон Азербайджани О лицензиях и разрешениях от 15.03.2016 года.

[https://base.spinform.ru/show\\_doc.fwx?rgn=85079](https://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=85079)

<sup>16</sup> Закон Армении О Лицензировании от 30.05.2001 года. <https://www.arlis.am/DocumentView.aspx?docID=67471>

<sup>17</sup> Закон Грузии О лицензиях и разрешениях, 24.06.2005 года.

<https://matsne.gov.ge/ru/document/view/26824?publication=87>

<sup>18</sup> Закон Казахстана “О разрешениях и уведомлениях” от 16.05.2014 года.

[https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31548200&pos=3;-109#pos=3;-109](https://online.zakon.kz/Document/?doc_id=31548200&pos=3;-109#pos=3;-109)

<sup>19</sup> Закон Кыргызии О лицензионно-разрешительной системе в Кыргызской Республике от 19.10.2013 года № 195. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/205058>

<sup>20</sup> Закон РФ О лицензировании отдельных видов деятельности. Принят ГД 22.04.2011 года. Одобрен СФ 27.04.2011 года. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102147413>

<sup>21</sup> Закон Узбекистан О лицензировании, разрешительных и уведомительных процедурах. Принят Законодательной палатой 5 марта 2021 года. Одобрен Сенатом 23.04.2021 года. <https://www.lex.uz/acts/5511900?ONDATE=15.07.2021%2000#5518717>

- тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн төрлүүдийг тогтоох (Армени, Гүрж, Казахстан, Киргиз) гэх мэт.

Эдгээр улсуудад тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн харилцааг дээрх бие даасан хуулиас гадна холбогдох салбарын хуулиудаар зохицуулж байна. Тухайлбал, **Гүрж Улсад** байгаль орчны салбарын зөвшөөрлийг Байгаль орчинд нөлөөлөх зөвшөөрлийн тухай, Усны тухай, Агаар мандлын агаарыг хамгаалах тухай, ашигт малтмал олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Газрын хэвлийн тухай хуулиар, нефть, байгалийн хийн олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Нефть ба байгалийн хийн тухай хуулиар, цэргийн зориулалттай бүтээгдэхүүний зөвшөөрлийг Цэргийн болон давхар зориулалттай бүтээгдэхүүнд хяналт тавих тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

**Азербайжан Улсын** тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь тус улсын Үндсэн хууль, Аж ахуйн нэгжийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэх бол **Киргиз Улсад** Үндэсний банк, банк, банкны үйл ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

**Казахстан Улсад** аж ахуй эрхлэх эрхийг хангах эрх зүй, эдийн засаг болон нийгмийн нөхцөл, баталгааг тодорхойлж, аж ахуйн нэгж, төр хоорондын харилцаа, тэр дундаа аж ахуй эрхлэхэд төрийн зохицуулалт, дэмжлэгтэй холбоотой харилцааг **Аж ахуйн үйл ажиллагааны кодексоор** зохицуулдаг. Энэ кодексын **106 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдлийн талаарх төрийн зохицуулалт мөн Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжид тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоно.**

Армени, ОХУ-ын хувьд зөвхөн тусгай зөвшөөрлийг зохицуулжээ. **ОХУ-д** тусгай зөвшөөрлийн хууль тогтоомж нь тус улсын Үндсэн хууль, холбооны болон ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоомжоос бүрдэнэ. Тухайлбал, Үндсэн хуулийн хэм хэмжээ нь тусгай зөвшөөрлийн харилцааг шууд бус байдлаар зохицуулж, эрх зүйн хязгаар, түүний үндсийг тогтоосон. Үүний дараа Иргэний кодекс тухулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл шаардагдах тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь тусгай зөвшөөрөл авсны дараа үүсэх зэрэг журмыг хамгийн нийтлэг байдлаар тодорхойлжээ. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөрчилд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

ОХУ-ын зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай холбооны хууль нь төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэд, хувиараа бизнес эрхлэгчдийн хоорондын тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг юм. Энэ хуулиар тусгай зөвшөөрлийн зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлох, хязгаарлах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны төрөл, олгох байгууллагын зарчим, тогтолцоо, бүрэн эрх, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг олгох журмыг тогтоожээ.

Харин дээрх хуульд хамаарахгүй тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн харилцааг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Жишээлбэл, цөмийн энерги ашиглах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, түүний дотор цөмийн байгууламжийн ажилтанд зөвшөөрөл олгох журмыг Цөмийн энергийг ашиглах тухай хуулиар зохицуулж байна. Мөн боловсрол, харилцаа холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг салбарын тусгай зөвшөөрлийг холбогдох хуулиудаар зохицуулж байна.

Үүний дараа тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудын бүрэн эрхийг тогтоох, тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөл, журмыг зохицуулсан ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газрын актууд хамаарч байна.

Харин **Армени Улсад** эрчим хүч, цахим харилцаа холбоо, усны салбарын тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай, Цахим харилцаа холбооны тухай, Телевиз, радиогийн тухай хуулиуд болон Усны тухай кодексоор зохицуулдаг.

## **2.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо**

**Шотланд Улсын** Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар Лицензийн зөвлөлтэй байна. Тус зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгохоос гадна, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихаар хуульчлагдсан байна. Лицензийн зөвлөл нь орон нутагт салбар нэгжтэй байна. Тухайн нутаг дэвсгэртээ лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилон ажиллуулахыг хуульд тусгажээ.

Тус хуулиар “тусгай зөвшөөрөл олгох” 5 зорилтыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Олон нийтийг таагүй байдлаас урьдчилан сэргийлэх;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах;
- Хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах зэрэг байна.

### **Абердиний Лицензийн зөвлөл:<sup>22</sup>**

Шотланд Улсад Тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал дүгнэлтийг боловсруулах эрх бүхий Абердиний лицензийн зөвлөл ажилладаг байна. Абердиний лицензийн зөвлөл нь 9 гишүүнтэй 2 сар тутамд нэг удаа Мягмар гарагт 10:30 цагт хуралддаг. Абердиний лицензийн зөвлөлөөс авах боломжтой тусгай зөвшөөрлийн дараах төрлүүд байдаг. Үүнд:

- архи согтууруулах ундаа худалдах;
- мөрийтэй тоглоом тоглох;
- амьтан тэжээх байгууламжаар хангах;
- усан онгоц түрээслэх;
- караван болон кемпийн газар ашиглах;
- хөргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх;
- спортын үйл ажиллагаа эрхлэх;
- металл борлуулах;
- оройн цагаар үйл ажиллагаа эрхлэх;
- оператор ажиллах;
- буяны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;
- морин спортоор хичээллэх;
- насанд хүрэгчдэд зориулсан дэлгүүр ажиллуулах;
- шивээс хийх, арьс цоолох үйлчилгээ эрхлэх;
- спортын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллуулах;
- газрын тосны агуулах байгуулах;
- цонх цэвэрлэгээний үйлчилгээ эрхлэх;
- шөнийн цагаар үйлчилгээ эрхлэх;
- амьтны хүрээлэн ажиллуулах.

Абердиний лицензийн зөвлөл нь бүтцийн хувьд Аудит эрсдэл, хяналтын хороо, Лицензийн хороо, Олон нийтийг хамгаалах хороо зэрэг 12 хороотойгоор үйл ажиллагаа эрхэлдэг байна.

<sup>22</sup> <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-board>

Абердиний лицензийн зөвлөл болон хороодын үйл ажиллагааг тус зөвлөлийн байнгын захирамжаар зохицуулдаг.

Судалгааны асуудалтай холбогдуулан Лицензийн хороог<sup>23</sup> товч судаллаа. Тус хороо нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх зэргийг хуулийн дагуу шийдвэрдэнэ. Тус хорооноос олгож буй зөвшөөрлийн төрлүүдийг дараах байдлаар оруулав.

**Лицензийн хорооноос олгож буй тусгай зөвшөөрлийн төрлүүд:** металл диллерийн, олон нийтийн зугаа цэнгэлийн байгууламжийн лиценз, зэвсэг борлуулах, такси захиалгын албаны лиценз.

**Лицензийн хорооноос олгож буй зөвшөөрлийн төрлүүд:** такси болон түрээсийн машин ашиглах зөвшөөрөл, такси болон хувийн түрээсийн машины жолооч, онгоц түрээслэх, гудамжны худалдаа эрхлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, шөнийн цагаар үйлчилгээ эрхлэх, спорт заал, хутга, сэлэм зэрэг зэвсэг эзэмших, жагсаал цуглаан зохион байгуулах зэрэг байна.

Орон нутагт лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилно гэж Лицензийн тухай хуульд заажээ. Лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилохдоо хуульд заасан шаардлагын дагуу ур чадвар, туршлагыг харгалзан үзэж тогтоосон журмын дагуу томилно. Лицензийн стандарт хариуцсан ажилтан нь тухайн нутаг дэвсгэртээ хуулийн дагуу олгосон чиг үүргийн дагуу эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Үүнд:

- тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, хяналт тавих;
- тусгай зөвшөөрлийн эрхийн шаардлага хангаагүй болон тухайн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл өргөдөл гаргагчын аливаа үйлдлийн талаар Лицензийн зөвлөлд мэдэгдэх;
- хоорондын маргаан, үл ойлголцлоос зайлсхийх, шийдвэрлэх зорилгоор эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- лиценз эзэмшигчийн ажлын байранд хэдийд ч нэвтэрч тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг шалгах;
- хяналт шалгалт хийх хуульд заасан бусад шаардлагыг тавих;
- стандарт хариуцсан ажилтан шаардлагатай гэж үзвэл ажлын байранд илэрсэн зөрчил болон олдсон эд зүйлс, баримт бичигт шалгалт хийх, хураах, хуулбарлан авах, авах эрхтэй.

Лицензийн стандарт хариуцсан ажилтан нь тусгай зөвшөөрөл эсхүл зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн буюу зөрчиж байгаа гэж үзвэл мэдэгдэл хүргүүлж дараах арга хэмжээг авна. Үүнд:

- мэдэгдэлд заасан зөрчлийг арилгах, арга хэмжээ авахуулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- мэдэгдэл аваад шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг дахин хянах, зөвлөлд мэдээлэл хүргүүлэх.

**БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд** хяналт, шалгалттай холбоотой дараах зохицуулалт туссан байна.

Захиргааны тусгай зөвшөөрлийг үнэлэх, цуцлах, хяналт тавих<sup>24</sup> Тусгай зөвшөөрөл тогтоосон (бий болгосон) байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлийг үнэлнэ.

<sup>23</sup> <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-committee>

<sup>24</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 20 дугаар зүйл.



Захиргааны тусгай зөвшөөрлийн гүйцэтгэх байгууллага нь захиргааны тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл байх шаардлагатай эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох дүгнэлтийг тусгай зөвшөөрөл тогтоосон байгууллагад мэдээлнэ.

Иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага захиргааны тусгай зөвшөөрөл тогтоох, хэрэгжүүлэх талаар тухайн зөвшөөрлийг тогтоосон байгууллага, гүйцэтгэх байгууллагад санал гаргаж болно.

Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийн 52 дугаар зүйлд зааснаар Төрийн зөвлөл тусгай зөвшөөрлийг хэрэгжүүлэх журмыг холбогдох хууль тогтоомж, захиргааны журмаар зохицуулна.

Захиргааны дээд байгууллага нь тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд доод шатны байгууллагад тавих хяналт, шалгалтыг чангатгаж, хууль бус үйлдлийг цаг тухайд нь арилгана.<sup>25</sup> Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд баримт бичгийн шалгалт хийх замаар хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Захиргааны байгууллага хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүнд гэнэтийн шалгалт хийх, үйлдвэрт газар дээр нь үзлэг хийж болдог.

Шалгалт явуулахдаа хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвлөлдөх бөгөөд холбогдох материалыг бүрдүүлж өгөхийг шаардаж болно.

Мөн олон нийтийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдалд шууд хамааралтай чухал техник, тоног төхөөрөмжид хууль тогтоомж, захиргааны журмын дагуу үе үе үзлэг шалгалт хийх ба тэнцсэн бол нотлох баримт бичиг олгодог.<sup>26</sup>

Хувь хүн, байгууллага захиргааны тусгай зөвшөөрлийн хууль зөрчсөн аливаа үйл ажиллагааг илрүүлсэн бол энэ тухай холбогдох захиргааны байгууллагад мэдэгдэх бөгөөд зөрчлийг цаг тухайд нь хянан шийдвэрлэнэ.

Залилан мэхлэх, хахууль өгөх замаар тусгай зөвшөөрөл авсан бол хуульд заасан журмын дагуу захиргааны шийтгэл ногдуулна. Тусгай зөвшөөрөл нь нийтийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдалд шууд хамаарах бол өргөдөл гаргагч нь түүнээс хойш 3 жилийн дотор дахин хүсэлт гаргахгүй ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 79 дүгээр зүйлд заасан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах зөрчлийг гаргасан бол хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх ба гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

1. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг өөрчлөх, худалдах, худалдан авах, түрээслэх, зээлдүүлэх, бусад хууль бус аргаар тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;
2. тусгай зөвшөөрлийн хүрээнээс хэтэрсэн үйл ажиллагаа явуулах;
3. хяналт, шалгалт хариуцсан захиргааны байгууллагаас холбогдох мэдээллийг нуун дарагдуулах, хуурамч материал илгээх, үйл ажиллагааг нь харуулсан жинхэнэ материал илгээхээс татгалзах;
4. хууль, тогтоомжид заасан бусад хууль бус үйлдэл.<sup>27</sup>

Төрийн зөвлөлөөс Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулиас гадна БНХАУ-ын **Захиргааны**

<sup>25</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 60 дугаар зүйл.

<sup>26</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 62 дугаар зүйл.

<sup>27</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 80 дугаар зүйл.

**тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоолыг** 2013 онд батлан хэрэгжүүлж байна. Энэ тогтоол нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтад хатуу хяналт, зохицуулалт хийх зорилготой юм. Уг зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд

- тусгай зөвшөөрлийн стандартыг хатуу тогтоох;
- тусгай зөвшөөрөл олгох хяналтыг стандартчилах;
- тусгай зөвшөөрөл бий болгоход тавих хяналтын чангатгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2001 оноос хойш Хятадын Төрийн зөвлөл Бизнес хийх таатай орчныг бүрдүүлэх үүднээс 2400 зөвшөөрлийг цуцалсан буюу доод шатны эрх баригчдад шилжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоосон олон тооны дүрэм журмыг цуцалж, эдгээр газраас тусгай зөвшөөрөл тогтоохыг хатуу хязгаарласан. Хууль, захиргааны дүрэм, орон нутгийн дүрэм журам, мужийн түвшний ардын засгийн газраас бусад норматив баримт бичигт захиргааны тусгай зөвшөөрөл тогтоохыг хатуу хориглосон байна.

**Сингапур Улс** нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг бие даасан хуулиар бус холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Иймээс аж ахуйн нэгжийн зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлд тавих хяналтыг тухайн зөвшөөрөл олгосон байгууллага хэрэгжүүлдэг байна. Иймээс зарим төрлийн тусгай зөвшөөрлийг зохицуулдаг хууль болон хяналт тавих эрх бүхий байгууллагыг үзүүлбэл:

*Хүснэгт. Тусгай зөвшөөрлийн зарим төрлүүдийг зохицуулдаг хууль, түүнийг олгодог, хянадаг байгууллага*

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Зохицуулж буй хууль	Зөвшөөрөл олгох, хяналт тавих байгууллага
1.	Банкны тусгай зөвшөөрөл	Банкны тухай хууль <sup>28</sup>	Валют зохицуулалтын газар
2.	Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Барилгын хяналтын тухай хууль <sup>29</sup>	Барилга, угсралтын газар
3.	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Даатгалын тухай хууль <sup>30</sup>	Валют зохицуулалтын газар
4.	Цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрөл	Цахилгаан, эрчим хүчний тухай хууль <sup>31</sup>	Эрчим хүчний удирдах газар
5.	Эмийн сангийн тусгай зөвшөөрөл	Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль <sup>32</sup>	Анагаах ухааны газар
6.	Согтууруулах ундаа нийлүүлэх тусгай зөвшөөрөл	Согтууруулах ундааны хяналтын (нийлүүлэлт ба хэрэглээ) тухай хууль <sup>33</sup>	Цагдаагийн газар
7.	Тамхи импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Тамхины тухай хууль <sup>34</sup>	Анагаах ухааны газар

Тухайлбал, Засгийн газрын агентлаг болох Анагаах ухааны газар нь тамхи импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хууль, Тамхины (зар сурталчилгаа, борлуулалтын хяналт, тусгай зөвшөөрөл олгох) журам<sup>35</sup> болон

<sup>28</sup> Банкны тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/BA1970>

<sup>29</sup> Барилгын хяналтын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/BCA1989>

<sup>30</sup> Даатгалын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/IA1966>

<sup>31</sup> Цахилгаан, эрчим хүчний тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/EA2001>

<sup>32</sup> Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/HPA2007>

<sup>33</sup> Согтууруулах ундааны хяналтын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/LCSCA2015>

<sup>34</sup> Тамхины тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993>

<sup>35</sup> Tobacco (Control of Advertisements and Sale) (Licensing) Regulations 2017 <https://sso.agc.gov.sg/SL/TCASA1993-S763-2017?DocDate=20211230>

дагалдах бусад хууль, тогтоомжид<sup>36</sup> заасан нөхцөл, шаардлагыг үндэслэн олгох, өөрчлөх, сунгах, цуцлах, хүчингүй болгох шийдвэрийг гаргадаг.

**Армени Улсад** Төв Банк, Төрийн үйлчилгээний зохицуулах хороо, Телевиз, радиогийн үндэсний хороо, Засгийн газраас эрх олгосон яам, агентлагууд нь Тусгай зөвшөөрөл олгох тухай хуульд заасан үйл ажиллагааны төрлүүдийн тусгай зөвшөөрлийг олгоно. Эдгээр байгууллагуудын талаар тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудаар зохицуулдаг.

Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудын нэг болох **Телевиз, радиогийн үндэсний хороо** (ТРҮХ) нь төрийн байгууллагын статустай хараат бус байгууллага бөгөөд Телевиз, радиогийн тухай хууль<sup>37</sup> болон тус хорооны дүрмийг үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Түүний дүрмийг тус улсын Үндэсний Ассамблейгаас батална.

ТРҮХ нь дараах эрх, үүрэгтэй:

- радио давтамжийн олон нийтийн болон өрсөлдөөнт хуваарилалтыг явуулдаг тусгай зөвшөөрлийн маягтыг батлах;
- телевиз, радиогийн хувийн хэвшлийн байгууллага (цаашид “телевиз, радиогийн компани”)-д тусгай зөвшөөрөл олгох;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг гаргаж, нийтлэх, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийн биелэлтэд хяналт тавих;
- телевиз, радиогийн байгууллагад кодтой нэвтрүүлэг явуулахыг зөвшөөрөх;
- холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- телевиз, радиогийн нэвтрүүлэг бэлтгэх техникийн үзүүлэлтүүд, түүнчлэн техникийн хэрэгсэл нь стандарт, олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөлд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;
- Телевиз, радиогийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд тухайн телевиз, радиогийн нэвтрүүлгийн үйл ажиллагааг шүүхийн шийдвэр гартал түдгэлзүүлэх;
- хуульд заасан журмын дагуу олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

Тус хороо нь ажлын албатай ба түүний бүтэц, орон тоог ТРҮХ-ны даргын санал болгосноор ТРҮХ батална. ТРҮХ-ны үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. ТРҮХ нь жил бүр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа тус улсын Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлэхээс гадна хэвлэлд нийтэлнэ.

ТРҮХ-ны бүрэлдэхүүний хувьд 9 гишүүнтэй, тэднийг тус улсын Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно. Нэг хүнийг ТРҮХ-ны гишүүнээр хоёроос дээш удаа томилохгүй. Тус хороо нь дарга, дэд даргаа гишүүдээсээ сонгоно.

ТРҮХ-ны гишүүнээр дараах хүмүүс байж болохгүй:

- намын удирдах байгууллагын гишүүн;
- гадаадын иргэн;
- аливаа телевиз, радио компанийн үүсгэн байгуулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хувьцаа эзэмшигч, эсхүл оролцогч;
- төрийн болон хувийн хэвшлийн телевиз, радиогийн байгууллагын дарга, ажилтан.

ТРҮХ-ны гишүүд нь сурган хүмүүжүүлэх, шинжлэх ухаан, уран бүтээлийн ажлаас бусад цалинтай ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэхгүй.

Дээр дурдсан тусгай зөвшөөрөл олгодог байгууллагууд нь **Тусгай зөвшөөрлийн хороо** (ТЗХ)-г (лицензирующие комиссия) байгуулах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох,

<sup>36</sup> Дагалдах хууль тогтоомж. <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993?ViewType=SI>

<sup>37</sup> Закон Республики Армения О телевидении и радио. Принят 09.10.2000.  
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1464&lang=rus#5>

түдгэлзүүлэх, цуцлахад тус хорооны дүгнэлтийг үндэслэнэ. Харин тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, дахин олгоход ТЗХ-ны дүгнэлт шаардлагагүй.

ТЗХ-ны дүгнэлтийг Тусгай зөвшөөрлийн тухай хууль болон тусгай зөвшөөрөл олгодог дээрх байгууллагуудын баталсан ТЗХ-ны дүрэмд заасан журмын дагуу гаргана.

ТЗХ-ны хурлыг дараах журмаар явуулна:

- ээлжит хурлын зарыг тухайн асуудлыг хэлэлцэхээс 7 хоногийн өмнө өргөдөл гаргагч буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “уригдсан этгээд”)–д мэдэгдэх ба 5-аас доошгүй хоногийн өмнө тус улсын олон нийтийн мэдээллийн албан ёсны цахим хуудас (<http://www.azdarar.am>)–д нийтэлнэ;
- ТЗХ-ны гишүүдийн талаас илүү хувь нь оролцсон хурлыг хүчинтэйд тооцно;
- хурлын дарга хамгийн түрүүнд хэлэлцэх асуудлыг, хуралдаанд уригдсан этгээдийг болон өргөдөл, бусад материалын агуулгыг танилцуулах ба асуудлыг хэлэлцэхэд оролцож байгаа хүмүүст эрх, үүргийг тайлбарлана;
- хурлаар асуудлыг нээлттэй хэлэлцэнэ. Төрийн, албаны болон банкны нууцыг агуулсан мэдээлэлтэй холбоотой асуудлыг хаалттай хэлэлцэнэ;
- асуудлыг хэлэлцэх явцад арилжааны нууц агуулсан мэдээлэл илэрсэн тохиолдолд уригдсан этгээдийн хүсэлтээр хаалттай хуралдаж болно;
- асуудлыг хэлэлцэхэд сэтгүүлч, мэргэжилтэн, албан тушаалтан болон бусад хүмүүс нээлттэй оролцож болно. Хурлын аудио болон дүрс бичлэг хийж болно;
- асуудлыг хэлэлцэж дууссаны дараа ТЗХ шийдвэрээ гаргана. Шийдвэрээ тусдаа өрөөнд, хаалттай хаалганы цаана гаргах буюу шийдвэр гарах үед тус өрөөнд зөвхөн ТЗХ-ны гишүүд байна;
- ТЗХ-ны шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар хаалттай, нууц санал хураалтаар гаргана. Хэрэв санал тэнцсэн бол уригдсан этгээдийн талд шийдвэр гаргасан гэж үзнэ;
- асуудал хэлэлцэх явцад хурлын тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд ТЗХ-ны дүгнэлтийн агуулгыг тусгаж, хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна;
- хууль зөрчиж гаргасан ТЗХ-ны дүгнэлтийг хүчингүйд тооцно;
- ТЗХ-ны дүгнэлтийг олон нийтийн мэдээллийн албан ёсны цахим хуудас (<http://www.azdarar.am>)–д нийтэлж, урьсан этгээдэд илгээнэ.

Уригдсан этгээд дараах эрхтэй:

- мэргэжилтэн, шинжээч, аудитор, хуульч, орчуулагчийг урих;
- үг хэлэх, ТЗХ-ны гишүүдийн асуултад хариулах, өргөдөл гаргах (мөн түүний ашиг сонирхлыг хамгаалагчид).

ТЗХ-ны дүгнэлт гаргасан өдөр нь тусгай зөвшөөрөл олгох байгууллагын даргад шилжүүлнэ. Зөвшөөрөл олгох байгууллага нь ийнхүү дүгнэлт ирүүлснээс хойш 2 хоногийн дотор тус дүгнэлтийг үндэслэн шийдвэрээ гаргана. Хэрэв заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол зөвшөөрөл олгох байгууллагын шийдвэрийг хорооны шийдвэр гэж үзнэ.

Зөвшөөрөл олгох байгууллагын татгалзсан шийдвэрийг шүүхэд, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж болно.

Тусгай зөвшөөрлийг дараах журмаар түдгэлзүүлнэ. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгох байгууллага зөвхөн ТЗХ-ны дүгнэлтээр хуульд заасан шаардлагыг зөрчсөний улмаас үйл ажиллагааг нь түдгэлзүүлнэ;
- ТЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана;

- хуульд заасан шаардлагыг зөрчсөн өдрөөс хойш 3 сарын дотор, зөрчлийг үргэлжлүүлсэн буюу удаан хугацаагаар гаргасан бол түүнийг илрүүлснээс хойш 3 сарын дотор тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг түдгэлзүүлж болно;
- тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг ТЗХ хэлэлцэж дүгнэлт гарснаас хойш 15 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг зохих ёсоор шилжүүлээгүй, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчид илгээгээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг татгалзсанд тооцно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох байгууллага ижил үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах тухай асуудлыг дахин гаргахгүй.

**Азербайжан Улсын** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд зааснаар “тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцоо” гэдэгт дараах үйл явцыг багтаана. Үүнд:

- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлийг тогтоох;
- тэдгээрийг олгох;
- тэдгээрийн хуулбар, нэмэлт материалыг гаргаж өгөх;
- тэдгээрийг дахин олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;
- тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд хяналт тавих зэрэг болно.

Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар хэд хэдэн төрийн байгууллагууд бүх зөвшөөрөлд хяналт тавьж ажиллана. Үүнд:

- 1) тусгай зөвшөөрөл олгох байгууллага;
- 2) зөвшөөрөл олгох байгууллага;
- 3) төрийн эрх бүхий байгууллага.

**Тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгох байгууллагуудыг** хуулиар болон Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно. Эдгээр байгууллагууд нь аливаа зөвшөөрөл олгохтой холбоотой бүхий л ажиллагаа (тэдгээрийн хуулбар, нэмэлт материалыг гаргаж өгөх, тэдгээрийг дахин олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох)-г хэрэгжүүлэх, олгогдсон бүх зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх ба тэдгээрт хяналт тавихтай холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- аливаа зөвшөөрлийн бүртгэлд мэдээлэл оруулах, шинэчлэгдэх бүрд энэ тухай мэдээллийг тухайн зөвшөөрөлд хяналт тавих эрх бүхий байгууллагад илгээх;
- салбарын хуулиар олгож байгаа зөвшөөрлүүдэд хяналт тавих.

Харин **төрийн эрх бүхий байгууллага** нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд буюу Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны төрөлд олгох зөвшөөрлүүдэд хяналт тавина.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг Аж ахуй эрхлэгчдэд тавих хяналтыг зохицуулах, бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ. Энэ хуулиар аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр явуулж буй хяналтын зорилго, зарчим, түүнийг зохион байгуулах журам, хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтны эрх, үүрэг, аж ахуй эрхлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдуулан тавих шаардлагыг зохицуулсан байна. (Энэхүү хууль<sup>38</sup> нь төлбөртэй мэдээлэл болно.)

**Гүрж Улсад** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн дагуу үндэслэл бүхий өргөдлийн үндсэн дээр үйл ажиллагааны цар хүрээ, хэлбэрээс хамаарч тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд олгодог. Аливаа зөвшөөрөл

<sup>38</sup> Закон Азербайджанской Республики О регулировании проверок, проводимых в области предпринимательства и защите прав предпринимателей от 2 июля 2013 года №714-IV.Q.  
[http://base.conform.ru/show\\_doc.php?doc=64236](http://base.conform.ru/show_doc.php?doc=64236)

олгох байгууллагууд нь тухайн зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг дараах нийтлэг журмаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- зөвшөөрөл эзэмшигчид шалгалт явуулах тухай шийдвэрийг танилцуулна;
- зөвшөөрөл эзэмшигчээс аливаа зөвшөөрлийн нөхцөлийг биелүүлэхтэй шууд холбоогүй асуудлыг танилцуулахыг, эсхүл баталгаажуулахыг шаардахгүй;
- зөвхөн зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд газар дээр нь шалгах ба үүнд эрх бүхий байгууллагын шийдвэрээр захиргааны бусад байгууллагын төлөөлөгчид хамрагдаж болно;
- шалгалтын үед тусгай бүртгэл хөтөлж, дүгнэлт гаргана;
- хуульд өөрөөр заагаагүй бол жилд зөвхөн нэг удаа аливаа зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд хяналт тавина.

Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд дараах журмаар хяналт тавина. Үүнд:

- тусгай зөвшөөрлийн нөхцөлийг биелэлтэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайланг хянах замаар хяналтаа хэрэгжүүлнэ –
  - тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийн хооронд тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийн тайланг ирүүлнэ;
- хэрэв ирүүлсэн тайланд тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийн талаар тодорхой мэдээлэл байхгүй бол эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийг баталгаажуулсан тайланг гаргаж өгөх тодорхой хугацаа өгөх ба шаардлагатай бол тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй холбоо барина –
  - тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээрх шаардлагыг биелүүлээгүй бол хуулиар тогтоосон хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

**Казахстан Улсад** аливаа зөвшөөрлийн хяналтыг **төрийн хяналт, шалгалтын байгууллагууд** болон **орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд** хэрэгжүүлнэ.

Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулиар “зөвшөөрлийн хяналт”-д зөвшөөрөл олгох байгууллагуудын хэрэгжүүлэх дараах хяналтыг хамааруулсан байна. Үүнд:

- аливаа зөвшөөрлийг олгохоос өмнө – өргөдөл гаргагчийн тухайн зөвшөөрлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд;
- аливаа зөвшөөрлийг олгосны дараа – тухайн зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд тус тус хяналт тавина.

Зөвшөөрлийн хяналтыг шалгалт болон урьдчилан сэргийлэх хяналт гэсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлнэ. Зөвшөөрөл олгосны дараах хяналтыг энэ хоёр хэлбэрээр нь шалгах бол зөвшөөрөл олгохоос өмнөх хяналтыг тухайн субъект (объект) дээр очиж шалгана.

Аж ахуйн үйл ажиллагааны кодексын 87 дугаар зүйлд зааснаар төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагууд, тэдгээрийн нэгж, нутаг дэвсгэрийн нэгж болон орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд байх ба тэд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ.

**Киргиз Улсад** “тусгай зөвшөөрлийн хяналт” нь **тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий төрийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах үйл ажиллагаа бөгөөд үүнийг** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хуулийн 4 бүлэгт зохицуулсан байдаг.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас дээрх хууль, Сайд нарын Танхимаас баталсан “Зарим төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай журам”-аар тогтоосон тусгай

зөвшөөрлийн шаардлагыг тухайн зөвшөөрөл эзэмшигч хангаж байгаа эсэхэд шалгалт хийнэ.

Тусгай зөвшөөрлийн хяналтыг шалгалтын хэлбэрээр явуулах ба шалгалтыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгохоос өмнөх шалгалт – энэ шалгалтаар өргөдөл гаргагч тусгай зөвшөөрөл авахаас өмнө тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэргэжилтэн, байр, тээвэр тоног төхөөрөмж, бичиг баримт байгаа эсэхэд шалгалт хийнэ;
- тусгай зөвшөөрөл олгосны дараах шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд хийсэн төлөвлөгөөт шалгалт болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хийх шалгалт;
- төлөвлөгөөт бус шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авах, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хүлээн авсны дараа тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас хийдэг шалгалт, мөн өмнөх шалгалтаар тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг илрүүлсэн бөгөөд тухайн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавих шалгалт;
- төлөвлөгөөт шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу хийдэг шалгалт.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь төлөвлөгөөт бус шалгалтыг дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хийх эрхтэй. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг арилгах тухай актыг биелүүлэх хугацаа дууссан;
- **тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авсан, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хүлээн авсан (үүнд төрийн эрх бүхий байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ирүүлсэн мэдээлэл хамаарна);**
- тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дууссан;
- тогтоосон тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг эрт арилгасан баримтыг тогтоох зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс төлөвлөгөөт бус шалгалт хийлгэх тухай өргөдөл гаргасан зэрэг болно.

**ОХУ-д** тусгай зөвшөөрөл олгох ажиллагаанд түүнийг олгох, бүртгэл хөтлөх зэргээс гадна түүний хяналт багтаж байдаг. Тусгай зөвшөөрлийн хяналтыг зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн дагуу хэрэгжүүлэхдээ Төрийн болон хотын хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан журмыг баримтална.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус шалгалт явуулна. Төлөвлөгөөт шалгалтыг дараах тохиолдолд хийх ба үүнийг тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө тусгана. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан өдрөөс хойш нэг жилийн дараа;
- сүүлчийн төлөвлөгөөт шалгалт хийсэн өдрөөс хойш 3 жилийн дараа;
- эрсдэлд суурилсан хандлагыг ашиглан явуулах тусгай зөвшөөрлийн хяналтыг тусгай зөвшөөрлийн журмаар тогтоосон давтамжийн дагуу;



- эрүүл мэнд, боловсрол, нийгмийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ОХУ-ын Засгийн газраас төлөвлөгөөт шалгалт хийх давтамжийн дагуу.

**ОХУ-ын тусгай зөвшөөрлийн төлөвлөгөөт бүс (газар дээр нь хийх) шалгалт хийх үндэслэл нь Киргиз Улсын зохицуулалттай адил байна.** ОХУ-ын мөн тус улсын Ерөнхийлөгч, эсхүл Засгийн газрын зааврын дагуу тусгай зөвшөөрөл олгох байгууллагаас гаргасан тушаал, заавраар төлөвлөгөөт шалгалтыг хийдэг байна.

**Узбекистан Улсад** тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгох төрийн эрх бүхий байгууллагууд нь энэхүү үйл явцад хяналт тавих хэрэгжүүлэхдээ дараах эрхтэй. Үүнд:

- хувь хүн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн шаардлага, нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхэд газар дээр нь шалгалт хийх;
- шалгалт хийх явцад гарсан асуудлын талаар шаардлагатай мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардах, хүлээн авах;
- хяналт шалгалтын дүнг үндэслэн хувь хүн, хуулийн этгээд холбогдох шаардлага, нөхцөлийг зөрчсөн тухай акт гаргах;
- илэрсэн зөрчлийг арилгахыг иргэн, хуулийн этгээдэд үүрэг болгосон шийдвэр гаргах, зөрчлийг арилгах хугацааг тогтоох;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай өргөдөл шүүхэд гаргах;
- мэдэгдэл эзэмшигчийн үйл ажиллагаа (үйлдэл)-г түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэр гаргах, үйл ажиллагаа (үйлдэл)-г нь зогсоох тухай өргөдөл шүүхэд гаргах, мөн түүнд тухайн үйл ажиллагаа (үйлдэл) хийхийг хориглох;
- зөрчил гаргасан хуулийн этгээдийг хуулийн дагуу торгууль ногдуулах тухай өргөдөл гаргах;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгоход тухайн иргэн, хуулийн этгээдийг улсын хураамж төлөхгүйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх тухайн хүсэлт шүүхэд гаргах.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл болон мэдэгдлийн шаардлага, нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- тусгай цахим системээр дамжуулан зайнаас шалгах;
- хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу газар дээр нь очиж шалгах;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх ба тэднээс шаардлагатай мэдээллээ хүсэх.

Дээрх ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох этгээдээс холбоогүй мэдээлэл хүсэх, эсхүл шаардахыг хориглоно.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгох төрийн эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн шаардлага, нөхцөлийг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд хяналтын болон хууль сахиулах байгууллага эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

### **3. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн нэр төрөл, тоог тогтоох, өөрчлөлт оруулах процедур**

**БНХАУ**-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл тогтоох эрх, үүсгэн байгуулах субъект нь тодорхой бус байсны улмаас тусгай зөвшөөрлийн

тоо тасралтгүй нэмэгдэж, үүнээс улбаалан эдийн засаг, нийгмийн хөгжилд саад учирч, иргэн, хуулийн этгээд болон бусад байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль нь Нэгдүгээрт, захиргааны тусгай зөвшөөрлийн төрлийг тогтоох, Хоёрдугаарт, тусгай зөвшөөрөл тогтоох субъектийг хуульчлах, тусгай зөвшөөрөл олгох субъектийг хатуу хязгаарлаж, багасгах зорилготой батлагдсан байна.

Захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоохдоо эдийн засаг, нийгмийн хөгжлийн зарчимд нийцсэн, иргэд, хуулийн этгээд, бусад байгууллагын санаачлагаар хамгаалагдсан, нийтийн ашиг сонирхол, нийгмийн дэг журмыг хамгаалахыг зорьдог байна.<sup>39</sup>

Захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоох субъект: Захиргааны тусгай зөвшөөрлийг БХАТИХ, түүний Байнгын хорооноос баталсан хуулиар болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоодог.

Дараах тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулиар тогтооно.<sup>40</sup> Эдгээрт:

- улсын болон олон нийтийн аюулгүй байдал, экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдалтай шууд холбоотой тусгай үйл ажиллагааг хуулийн шаардлагад нийцүүлэн батална;
- байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх;
- төрөөс үйлчилгээ үзүүлдэг, нийтийн ашиг сонирхол шууд хамааралтай, тусгай ур чадвар, тусгай нөхцөл шаардсан мэргэжлүүд;
- орчин тойрондоо аюул учруулж болзошгүй тоног төхөөрөмж, барилга байгууламж, бүтээгдэхүүн, эд зүйлсийг стандарт, шалгуурын дагуу үзлэг, туршилт, хорио цээрийн аргаар шалгаж баталгаажуулсан байх;
- мэргэшлийн түвшин тогтоож тусгай зөвшөөрөл олгох байгууллага байгуулах;
- хууль тогтоомжийн дагуу захиргааны тусгай зөвшөөрөл олгож болох бусад асуудлууд.

Шаардлагатай тохиолдолд Төрийн зөвлөл тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргах хэлбэрийг баталж болохыг БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 14 дүгээр зүйлд заасан байна.

Бусад захиргааны тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ. Эрх бүхий байгууллагад мужийн болон аймгийн Ардын засгийн газрууд, автономит муж, эсхүл төв засгийн газрын шууд харьяа хотын захиргаа, орон нутгийн эрх бүхий байгууллагууд хамаарна.

Тусгай зөвшөөрлийг орон нутгийн журмаар тогтоох: Орон нутгийн эрх бүхий байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох хялбаршуулсан журмыг хэрэгжүүлдэг байна. Энэ нь Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль, захиргааны журмаар зохицуулагдаагүй үйл ажиллагаанд нэн яаралтай тусгай зөвшөөрөл олгох шаардлага гарсан бол дээрх хуулийн 12 дугаар зүйлд заасан зохицуулалтын хүрээнд тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагаас шийдвэрлэн холбогдох тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгодог. Ингэхдээ тухайн аймгийн Ардын засгийн газар журмаар, автономит муж, эсхүл төв засгийн газрын шууд харьяа хотын захиргаа захиргааны түр тусгай зөвшөөрлийг олгож болдог. Уг түр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шаардлагатай бол

<sup>39</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 11 дүгээр зүйл

<sup>40</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 12 дугаар зүйл

Ардын их хурал, түүний Байнгын хороонд анх олгосон байгууллага санал гаргана.<sup>41</sup>

Хууль тогтоомж батлах замаар тусгай зөвшөөрөл тогтоохдоо төсөл боловсруулагч байгууллага нь тусгай зөвшөөрөл олгох зайлшгүй шаардлага, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар сонсгол, санал асуулгыг иргэд, олон нийтээс авна. Энэ талаарх санал, дүгнэлтийг хууль тогтоомж батлах эрх бүхий байгууллагад өгнө.<sup>42</sup>

**Гүрж Улсын** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөлд тавигдах тусгай нөхцөлүүдийг хангасан эсэхийг бодит байдал дээр танилцсаны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно. Тус улсад тусгай зөвшөөрлийг үйл ажиллагааны болон ашиглалтын гэж хоёр ангилна:

а) үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тодорхойлсон үйл ажиллагаа эрхлэх эрх. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан тусгай нөхцөлүүдийг хангах үүрэгтэй бөгөөд уг тусгай зөвшөөрлийг өв залгамжлалаар болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэхгүй;

б) ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосон тус улсын тодорхой нөөцийг ашиглах эрх. Зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн тухай, Цахим харилцаа холбооны тухай хуулиудад зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгоно. Уг тусгай зөвшөөрлийг бусдад ашиглуулах, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх, өв залгамжлуулж болно.

**Казахстаны Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулиар зөвшөөрлийг аюулын түвшингээр нь дараах байдлаар хуваасан бөгөөд аюулын түвшинг зохицуулалтын нөлөөллийн дүн шинжилгээнд үндэслэж тогтооно:**

а) нэгдүгээр зэргийн зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөл - аюулын өндөр түвшингийн үйл ажиллагааны төрөлд олгоно;

б) хоёрдугаар зэргийн зөвшөөрөл буюу зөвшөөрөл - аюулын дунд түвшингийн үйл ажиллагааны төрөлд олгоно.

Судалгаанд хамрагдсан улсуудын хуулиар **зөвшөөрөл** бол тодорхой төрлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхой үйлдэл хийх, ажиллагаа хэрэгжүүлэх эрх бөгөөд зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар тогтоосон, эсхүл тухайн зөвшөөрөлд заасан нөхцөлийг хангах үүрэгтэй. **Азербайжаны** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийг дан ганц “зөвшөөрөл” (“разрешение”, “согласие”) гэхээс гадна “сертификат”, “гэрчилгээ” (“свидетельство”), “магадлан итгэмжлэл” (“аккредитация”) зэрэг нэр томъёог хэрэглэжээ.

**Казахстанд хоёрдугаар зэргийн зөвшөөрөл буюу зөвшөөрлийг** тухайн объектоос хамаарч дараах байдлаар **6 ангилна:**

- ангилал 1 - үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 2 - объектод олгох зөвшөөрөл;
- ангилал 3 - нэг удаагийн зөвшөөрөл;
- ангилал 4 - хязгаарлагдмал нөөцтэй, эсхүл квоттой үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 5 - хувь хүмүүст мэргэжлийн үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 6 - бүтээгдэхүүнд олгох зөвшөөрөл.

<sup>41</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 15 дугаар зүйл

<sup>42</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 19 дүгээр зүйл

**Киргизэд** тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны хугацаа, нутаг дэвсгэрийн хамрах хүрээ, өмчлөх эрх болон тусгай зөвшөөрлийн хэлбэрээр нь төрөлжүүлжээ:

**1) үйл ажиллагааны хугацаагаар нь:**

- а) хугацаагүй - хүчинтэй байх хугацааг хязгаарлахгүйгээр гаргасан;
- б) хугацаатай - тодорхой хугацаагаар олгосон (Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг зөвхөн улсын хязгаарлагдмал нөөц ашиглах, гадаад худалдааны болон тэсрэх бодис, бүтээгдэхүүн, зэвсэг, сумтай холбоотой үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон Үндэсний банкнаас олгосон тусгай зөвшөөрөл, мөн зэвсэг, сум, өндөр хортой бодис, аюултай ачаа зэрэгтэй холбоотой үйл ажиллагааны зөвшөөрөлд тогтооно.)

**2) нутаг дэвсгэрийн хамрах хүрээгээр нь:**

- а) үр нөлөө нь олон улсын гэрээний үндсэн дээр Киргиз Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан, түүнчлэн түүний хилээс гадуур;
- б) үр нөлөө нь Киргиз Улсын тодорхой нутаг дэвсгэрт, түүнчлэн зөвхөн улсын хязгаарлагдмал нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл, Үндэсний банкнаас олгосон тусгай зөвшөөрөл, мөн зэвсэг, сум, нууцаар мэдээлэл авах зориулалттай техникийн тусгай хэрэгсэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй холбоотой;

**3) өмчлөх эрхээр нь:**

- а) салгаж болохгүй (неотчуждаемые);
- б) салгаж болох (зөвхөн улсын хязгаарлагдмал нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой);

**4) тусгай зөвшөөрлийн хэлбэрээр нь:**

- а) цаасаар олгосон тусгай зөвшөөрөл;
- б) цахим тусгай зөвшөөрөл;
- в) үйл ажиллагааны хэмжээ, эрхийн багцаар (бараа экспортлох, импортлох үед);
- г) ерөнхий лиценз;
- д) нэг удаагийн тусгай зөвшөөрөл;
- е) тусгай лиценз.

Мөн **Казахстан, Узбекистан** улсуудад **мэдэгдэл** байх бөгөөд энэ нь мэдэгдэл гаргагчаас холбогдох журмын дагуу өөрийн үйл ажиллагаа (үйлдэл) эхлүүлэх (дуусгавар болгох) тухай эрх бүхий байгууллагад илгээсэн мэдээлэл юм.

Судалгаанд хамрагдсан ТУХН-ийн орнуудад тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг хуульд тодорхой жагсааж хуульчилсан байна. Жагсаалтыг хуулийн заалт дотор (Армени, Гүрж, Киргиз, ОХУ), эсхүл хавсралтад (Азербайжан, Казахстан, Узбекистан) тусгасан байна. (Хүснэгтээс үзнэ үү.)

*Хүснэгт. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны тоо*

№	Улсын нэр, эрх зүйн зохицуулалт	Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны (тусгай зөвшөөрлийн) тоо	Зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны (зөвшөөрлийн) тоо
1.	<b>Азербайжан –</b> Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн 1, 2, 3 дугаар хавсралт	Нийт 29 чиглэлийн 67 үйл ажиллагаа: • Тусгай зөвшөөрөл шаардлагатай 24 чиглэлийн 51 үйл ажиллагаа (үндэсний аюулгүй байдлын асуудлаас бусад) • Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тусгай зөвшөөрөлтэй 5 чиглэлийн 16 үйл ажиллагаа	Аж ахуй эрхлэх 86 зөвшөөрөл
2.	<b>Армени –</b> Тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн §43	Тусгай зөвшөөрөл олгох 19 чиглэлийн 78 үйл ажиллагаа	–
3.	<b>Гүрж –</b> Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн §6, 24	Нийт 61 төрлийн тусгай зөвшөөрөл: • үйл ажиллагааны 50 • ашиглалтын 11	64 төрлийн зөвшөөрөл
4.	<b>Казахстан –</b> <b>Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулийн 1, 2 дугаар хавсралт</b>	29 чиглэлийн 76 нэгдүгээр зэргийн зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөл	Нийт 212 хоёрдугаар зэргийн буюу зөвшөөрөл: • ангилал 1 - үйл ажиллагааны 55 • ангилал 2 - объектын 34 • ангилал 3 - нэг удаагийн 54 • ангилал 4 - хязгаарлагдмал нөөцтэй, эсхүл квот ашиглан үйл ажиллагааны 26 • ангилал 5 - хувь хүмүүст мэргэжлийн үйл ажиллагаа явуулах 26 • ангилал 6 - бүтээгдэхүүний 17
5.	<b>Киргиз –</b> <b>Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хуулийн §15-17</b>	Нийт 63 төрлийн үйл ажиллагаа: • тусгай зөвшөөрөлд хамаарах энгийн 56 төрлийн үйл ажиллагаа • тусгай зөвшөөрөлд хамаарах төрийн хязгаарлагдмал нөөцийг ашиглах 7 төрлийн үйл ажиллагаа	31 төрлийн үйл ажиллагаа
6.	<b>ОХУ –</b> Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн §12	Нийт 77 төрлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлд хамаарна (Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай болон Агаарын тухай, Газрын хэвлийн тухай, Зэвсгийн тухай, Даатгалын үйл ажиллагаа зохион байгуулах тухай, Төрийн нууцын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Эмийн эргэлтийн тухай хуулиар) • зөвхөн зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар 54 төрлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлд хамаарна	–
7.	<b>Узбекистан –</b> Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хуулийн 1, 2 дугаар хавсралт	49 тусгай зөвшөөрөл	120 зөвшөөрөл

Мэдэгдлийн хувьд Казахстан Улсын хуулиар **56**, Узбекистан улсын хуулиар **33** мэдэгдлийг тус тус тусгасан байна.

Судалгаанд хамрагдсан ТУХН-ийн улсуудад тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг ийнхүү хуулиар тогтоосон нь зөвхөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг жагсаалтыг өөрчлөх боломжтой. Мөн энэ талаар эдгээр улсуудын хуульд ч тусгасан байна. Тухайлбал, **Арменид** тусгай зөвшөөрөл олгох бол зөвхөн Тусгай зөвшөөрөл олгох тухай хуульд заасан үйл ажиллагааны төрөл тус бүрд тусгай зөвшөөрөл олгохоор, **Азербайжанд** зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлийг (санхүүгийн зах зээлийн салбараас бусад) зөвхөн Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосны дараа холбогдох салбарын хууль тогтоомжид тусгахаар тус тус хуульчилжээ.

Армени, Гүрж, Киргиз, ОХУ-ын хуульд тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөл олгохдоо эдийн засгийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хүний амь нас, эрүүл мэндийн, хүний амьдрах болон соёлын орчны, төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах зарчмыг баримтална.

**Арменид** тусгай зөвшөөрөл олгохдоо тус улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах, тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийн нэгдсэн жагсаалт гаргах, тусгай зөвшөөрөл олгох нэгдсэн журмыг тогтоох зэрэг зарчмыг баримтална. Харин **Гүржид** тодорхой үйл ажиллагаа нь хүний амь нас, эрүүл мэндэд, төрийн болон олон нийтийн ашиг сонирхолд аюул заналхийлж байгаа харилцааг тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тусламжтайгаар хэрэгжүүлж байна. Төрийн зохицуулалтыг гагцхүү тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгосноор энэ аюулыг бууруулах, улсын болон олон нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх боломжтой тохиолдолд хэрэгжүүлнэ.

Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистаны хуульд уг жагсаалтыг өөрчлөх шалгуурыг тогтоосон байна. Тухайн **үйл ажиллагаа** нь хүний ба иргэний амь нас, эрүүл мэндэд, мөн хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тухайн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгодог байна.

Тухайлбал, **Узбекистанд** хувь хүн, хуулийн этгээд тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх нь иргэний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, олон нийтийн аюулгүй байдал болон байгаль орчинд хохирол учруулж болзошгүй байдал нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох үндэслэл болно. **Казахстан Улсад тухайн үйл ажиллагааны аюулын түвшингээс нь хамаарч** тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн төрөлд өөрчлөлт оруулах **ба аюулын түвшинг нөлөөллийн дүн шинжилгээнд үндэслэж тогтооно.**

**Киргизэд** тусгай зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуурыг баримтална. Үүнд:

а) тухайн үйл ажиллагааны төрийн зохицуулалтын бусад арга нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийтийн болон төрийн аюулгүй байдалд учирч болзошгүй хохирлыг бууруулахгүй байх (тус улсын Сайд нарын танхимаас баталсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу хийсэн үнэлгээнд үндэслэнэ);

б) төрийн хязгаарлагдмал нөөцийг оновчтой удирдах зэрэг болно.

**ОХУ-д** тодорхой төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг мөн иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол, амь нас, эрүүл мэнд болон байгаль орчин, тус улсын ард түмний соёлын өвд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор

хийдэг. Харин тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрлийг хуулиар тогтоох нь тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үндсэн зарчмуудын нэг юм.

Гэвч тус улсад тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчны тулгамдсан асуудлуудын нэг нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлүүдийн тоо аж. Нэг талаас, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа цөөрсөн (жишээлбэл, барилга, аялал жуулчлал, тур операторын үйл ажиллагаа гэх мэт), тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулалтын бусад аргуудаар зохицуулах болсон (жишээлбэл, аудит, үнэлгээ болон барилгын үйл ажиллагаанууд өөрөө өөрийгөө зохицуулна (саморегулирование)). Нөгөө талаас, зарим тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүрээ өргөжсөн. 2014 онд Орон сууцны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор орон сууцны барилга барих тусгай зөвшөөрлийг шинээр нэвтрүүлсэн. Энэ нь орон сууцны менежментэд гарч байсан олон зөрчлийг арилгахад эерэг нөлөө үзүүлсэн байна.<sup>43</sup>

Мөн 2018 оноос биоанагаахын эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, амьтны хүрээлэн (зоопарк, зоосад), цирк, амьтны театр (зоотеатр), далайн усан сан (океанариум) зэрэгт амьтдыг арчлах, ашиглах зэрэг үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгож эхэлжээ.

Цаашид ч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны жагсаалтыг өргөжүүлэх шаардлага гарч ирсээр байна. Жишээлбэл, Япон, АНУ, Их Британи зэрэг улсуудад криптовалют, блокчэйн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөлтэй байдаг. Уламжлалт төдийгүй дижитал валютын солилцооны үйлчилгээ нь олон улсын санхүүгийн харилцан үйлчлэлийн шинэ түвшинг илэрхийлэх болсон. Иймд олон улсын санхүүгийн зах зээлд бүрэн нэвтрэх, энэ чиглэлээр гарч болзошгүй зөрчлөөс зайлсхийхийн тулд ОХУ-д криптовалют, блокчэйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэвтрүүлэх шаардлагатай хэмээн тус улсын судлаачид үзэж байна.<sup>44</sup>

ОХУ-д аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагагүй болсон талаар өмнө дурдсан. Гэвч судлаачдын үзэж байгаагаар, аялал жуулчлалын, мөн зочид буудлын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийг эргүүлж нэвтрүүлэх шаардлагатай. Жишээ нь, зочид буудлын бизнес нь АНУ, Герман болон бусад орнуудад тусгай зөвшөөрөл авдаг эерэг туршлага байна. ОХУ-ын хэмжээнд тусгай зөвшөөрлийн нэгдсэн шаардлагыг бий болгосноор аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ шинэ түвшинд гаргах боломжийг олгох аж.<sup>45</sup>

#### **4.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох**

**БНХАУ**-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд сонгон шалгаруулалт, дуудлага худалдаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

Дуудлага худалдаа<sup>46</sup> Захиргааны байгууллага нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо тендер, дуудлага худалдаа зэрэг шударга өрсөлдөөний аргыг хэрэглэн шийдвэр гаргадаг.

Тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаагаар олгох журам нь холбогдох хууль, захиргааны журамд нийцсэн байна. Дээрх журмын дагуу тендерт ялагч, худалдан авагчийг тодруулсны дараа ялагчид тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгодог.

<sup>43</sup> Л.В.Стандзонь. Система федерального законодательства о лицензировании: проблемы и перспективы законодательного регулирования. Актуальные проблемы российского права. 2018. No 12 (97).

<sup>44</sup> <https://cyberleninka.ru/>

<sup>45</sup> Мөн тэнд.

<sup>46</sup> Мөн тэнд.

<sup>46</sup> БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 53 дугаар зүйл



Захиргааны байгууллага Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийг зөрчиж тендер, дуудлага худалдааны хэлбэрийг батлаагүй, эсхүл тендер, дуудлага худалдаа явуулах журмыг зөрчсөн нь өргөдөл гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд өргөдөл гаргагч нь хуулийн дагуу нэхэмжлэл гаргаж болно.

БНХАУ-д Дуудлага худалдааны тухай хууль<sup>47</sup> (Auction Law of the People's Republic of China), Тендерийн урилга, тендерийн хууль<sup>48</sup> (Law of the People's Republic of China on Bid Invitation and Bidding) байдаг боловч эдгээр хуулиудаар зөвшөөрлийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг нарийвчлан зохицуулаагүй байна.

**Сингапур, Шотланд** улсуудад холбогдох хууль тогтоомж, түүнийг даган гарсан холбогдох журмын хүрээнд судлан үзэхэд дуудлага худалдаа болон сонгон шалгаруулалтаар олгож байгаа зохицуулалт байхгүй байна.

Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан зэрэг улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн харилцааг зохицуулж байгаа бие даасан хуулиудад тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгож болохыг заасан байна. Тухайлбал, **Арменийн** хуульд телевиз, радиогийн нэвтрүүлэг цацах болон хувийн мультиплексийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулах уралдааны үр дүнд тусгай зөвшөөрөл олгохоор хуульчилсан байна.

**Узбекистанд** тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-ын үндсэн дээр олгох бөгөөд түүнийг сонгон шалгаруулалт (тендер)-аар олгох журам, нөхцөлийг тус улсын Сайд нарын танхим тогтооно. Тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөлийг зохих ёсоор хангасан өргөдөл гаргагч нь тухайн зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-д давуу эрх эдлэх ба түүний санал нь сонгон шалгаруулалт (тендер)-д оролцож буй өөр өргөдөл гаргагчийн оновчтой саналтай тэнцсэн бол энэхүү давуу талыг хэрэглэнэ.

**Гүрж Улсад** ашиглалтын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох ба журмыг нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар судалгаанд хамрагдсан бусад орны бие даасан хуультай харьцуулахад илүү тодорхой зохицуулжээ.

Тус улсад баялаг ашиглах тусгай зөвшөөрлийн олголтыг уг зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтэд үндэслэн тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлнэ. Уг зөвшөөрлийг олгоход тухайн объектыг ашиглахтай холбоотой нэмэлт нөхцөл тавьж болох ба нэмэлт нөхцөлийг хуулиар тогтоох аж.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ашиглалтын тусгай зөвшөөрлийн объектын тоо, хэмжээ, ашиглах журмыг батлах;
- олон нийтийн болон төрийн эрх ашгийн үүднээс ашиглалтын тусгай зөвшөөрлийн объектын тоо хэмжээ, чанар, цаг хугацаа ба ашиглалтын хязгаарлалтыг тогтоох;
- дуудлага худалдааг олон нийтэд мэдээлэх;
- дуудлага худалдаанд оролцох хүсэлт хүлээн авах эцсийн хугацааг тухай бүр тогтоох;
- дуудлага худалдааны анхны үнийг болон тухайн тусгай зөвшөөрлийн хугацааг харгалзан тогтоох (Тухайн тусгай зөвшөөрлийн объектын шинж чанар, ашиглалтын технологийг харгалзан хугацааг нь тогтооно. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгохгүй);
- тусгай зөвшөөрлийн хугацааг Гүрж Улсын Засгийн газрын зөвшөөрлөөр сунгах;
- дуудлага худалдаа зохион байгуулах, ялагчийг тодруулах;
- тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох журмыг батлах.

<sup>47</sup> БНХАУ-ын Дуудлага худалдааны тухай хууль <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/alotproc366/>

<sup>48</sup> БНХАУ-ын Тендерийн урилга, тендерийн хууль <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/biabi226/>

Тухайн нэг нөөц ашиглах тусгай зөвшөөрлийн хүрээнд өөр тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй. Тухайн нэг нөөц ашиглах тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангасан, дуудлага худалдаагаар хамгийн өндөр үнийн санал болгосон этгээдэд уг тусгай зөвшөөрлийг олгоно.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээсэн, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг бүрэн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгч бүр дуудлага худалдаанд оролцох эрхтэй бөгөөд дуудлага худалдааг зарласнаас хойш 15-аас багагүй хоногийн дотор түүнд оролцох хүсэлтээ гаргана.

Дуудлага худалдааг дараах журмын дагуу зохион байгуулна. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь дуудлага худалдаа болохоос 1 сарын өмнө энэ талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсандаа байршуулна:
  - дуудлага худалдааг өөр цахим хуудсаар явуулах бол тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дуудлага худалдаа болохоос 3-аас багагүй хоногийн өмнө өөрийн цахим хуудсандаа байршуулна;
  - дуудлага худалдаа явагдах тухай мэдээллийг бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно;
- олборлолтын хэмжээ нь 500,000 куб метр/тонноос хэтрэхгүй бол эрчим хүч, түлш (газрын тос, байгалийн хийнээс бусад), уул уурхай-химийн түүхийн эд, эрдсийн бус түүхий эд, барилгын түүхий эд олборлох тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулах тухай мэдээллийг тусгай зөвшөөрөл олгогч байгууллага дуудлага худалдаа болохоос 15-аас багагүй хоногийн өмнө олон нийтэд зарлана:
  - дуудлага худалдааг өөр цахим хуудсаар явуулах бол тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дуудлага худалдаа болохоос 3-аас багагүй хоногийн өмнө өөрийн цахим хуудсандаа байршуулна;
  - дуудлага худалдаа явагдах тухай мэдээллийг бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно;
- олон нийтэд зарлахад дор дурдсан мэдээллийг оруулна:
  - a) тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын нэр;
  - b) ашиглалтын тусгай зөвшөөрлийн объект;
  - c) тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг хүлээн авах, дуудлага худалдаа болох хугацаа;
  - d) хуулиар тогтоосон тусгай зөвшөөрлийн нөхцөл;
  - e) тухайн объектыг ашиглахад тавигдах шаардлага;
  - f) ялагчийг тодруулах шалгуур;
  - g) тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэртэй холбоотой бусад мэдээллүүд;
  - h) тусгай зөвшөөрөл зэрэг болно.

Гүржийн Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар **гадна зар сурталчилгаа байршуулах зөвшөөрлийг** дуудлага худалдаагаар олгоно. Энэхүү зөвшөөрөл нь төрийн өмчит буюу нутгийн өөрөө удирдах байгууллагын өмчид байгаа газар болон эд хөрөнгийн гадна байршуулах зар сурталчилгаанд хамаарна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөллийн байгууллага нь уг зөвшөөрлийг олгох шийдвэрийг гаргах бөгөөд дуудлага худалдаа явуулах, дуудлага худалдааны анхны үнэ тогтоох журмыг батална. Уг

зөвшөөрлийн нөхцөлийг биелүүлсэн, хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд уг зөвшөөрлийг олгоно.

**ОХУ**-ын Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгох харилцааг зохицуулаагүй, харин холбогдох салбарын хуулиудаар зохицуулжээ. Тухайлбал, тус улсын **Газрын хэвлийн тухай хуулийн**<sup>49</sup> дагуу ОХУ-ын хуульд заасны дагуу газрын хэвлийг ашиглахад геологийн болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгодог. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах нийтлэг журмыг Газрын хэвлийн тухай энэ хуулиар, нарийвчилсан харилцааг Газрын хэвлий ашиглалтын холбооны агентлаг (Роснедр)-ийн регламентаар тус тус зохицуулсан байна.

Холбооны болон орон нутгийн ач холбогдол бүхий газрын хэвлий, мөн түүнд хамааралгүй газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа Засгийн газраас тогтоосон журмын дагуу цахим хэлбэрээр явагдана. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу төрийн болон төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай адил тогтолцоогоор гүйцэтгэнэ.

Дуудлага худалдаа явуулах шийдвэр, дуудлага худалдааны комиссын бүрэлдэхүүнийг дараах байдлаар гаргана:

- 1) ОХУ-ын Засгийн газар – холбооны ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайтай холбоотой;
- 2) ОХУ-ын субъектүүдийн төрийн байгууллагууд – орон нутгийн ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайтай холбоотой;
- 3) газрын хэвлийн улсын санг удирдах холбооны байгууллага, эсхүл түүний орон нутгийн албууд – дээрхээс бусад газрын хэвлийн талбайтай холбоотой.

ОХУ-ын Засгийн газар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- холбооны ач холбогдол бүхий газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах журмыг тогтоох;
- газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаанд оролцогчдод тавигдах тусгай шаардлагыг тогтоох (ингэхдээ ОХУ-ын төрийн эрх бүхий байгууллагаас баталсан стратеги төлөвлөлтийн баримт бичгүүд, мөн ОХУ-ын бүх иргэд болон тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, бусад ашиг сонирхлыг харгалзана).

Дуудлага худалдааны зарыг дуудлага худалдаа болох өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө ОХУ-ын мэдээлэл, харилцаа холбооны “Интернет” албан ёсны цахим платформд байршуулна. Энэхүү цахим платформд мөн төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зарыг байршуулдаг байна.

Дуудлага худалдааны комисс нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хянан хэлэлцсэн тухай болон дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө, мөн дуудлага худалдаанд оролцохыг зөвшөөрөөгүй өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл, үүнд оролцохоос татгалзсан шалтгааныг тэмдэглэнэ. Дуудлага худалдаанд оролцох эрхтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн өргөдөл гаргагч нь дуудлага худалдааны комиссын гишүүд өргөдлийг хэлэлцэх протоколд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн дуудлага худалдааны оролцогч болно.

Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд ялагчийг тодруулахад тухайн оролцогчийн шинжлэх ухаан, техникийн түвшин, тухайн бүс нутагт ажилласан туршлага,

<sup>49</sup> Закон РФ "О недрах" от 21.02.1992. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_343/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_343/)

тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг, мөн газрын хэвлий ашиглах эрхийн нэг удаагийн төлбөрийн хэмжээг гол шалгуураа болгоно.

Зөвхөн нэг этгээдийн өргөдөл нь хуулийн шаардлага болон зарласан дуудлага худалдаа явуулах нөхцөлийг хангасан бол, эсхүл дуудлага худалдаанд зөвхөн нэг оролцогч оролцсон бол тухайн дуудлага худалдааг хүчингүй болсонд тооцно. Энэ тохиолдолд тухайн оролцогчид газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуудлага худалдааны нөхцөлөөр олгосонд тооцно.

Дуудлага худалдааны үр дүнгийн талаарх протоколд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- дуудлага худалдаанд оролцогчдын өргөдөл хуулийн шаардлага хангасныг;
- дуудлага худалдааны дүнг үндэслэн газрын хэвлийг ашиглах эрх буюу тусгай зөвшөөрөл олгох тухай комиссын шийдвэрийг;
- дуудлага худалдааны үр дүнгээр ялагчаар тодорсон (эсвэл дуудлага худалдаанд цорын ганц оролцогч) тухай мэдээллийг;
- газрын хэвлийн талбай ашигласны төлбөрийн нэг удаагийн төлбөрийн эцсийн дүн, түүнийг төлөх эцсийн хугацааны талаарх мэдээллийг.

Хэрэв дуудлага худалдааны ялагч нь газрын хэвлийн талбайг ашигласны төлбөрийн эцсийн дүнг төлөөгүй бол түүний дараагийн үнэ санал болгосон этгээдийг ялагчаар тодруулна.

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ****БНХАУ**

- “Хятад дахь лицензийн сорилтууд ба шилдэг туршлагууд тайлан” (2014) АНУ-Хятадын бизнесийн зөвлөл:  
<https://www.uschina.org/sites/default/files/Licensing%20Challenges%20and%20Best%20Practices%20in%20China-Jan%202014.pdf>
- БНХАУ-ын Төрийн зөвлөлийн цахим хуудас:  
[http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content\\_WS61f64f28c6d09c94e48a4906.html](http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content_WS61f64f28c6d09c94e48a4906.html)
- БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль:  
<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>
- БНХАУ-ын захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн тайлбар:  
<http://xzspj.nc.gov.cn/ncspj/zcjd/201912/4151afa2a3f1463eaab35ee76e7b792b.shtml>
- Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол:  
[http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content\\_1228.htm](http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content_1228.htm)
- БНХАУ-ын Дуудлага худалдааны тухай хууль:  
<http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/alotproc366/>
- БНХАУ-ын Тендерийн урилга, тендерийн хууль:  
<http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/biabl226/>

**Шотланд Улс**

- Шотланд Улсын Тусгай зөвшөөрлийн тухай хууль:  
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-scotland-act-2005>
- Абердиний лицензийн зөвлөлийн цахим хуудас:  
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-board>
- Абердиний лицензийн хороодын цахим хуудас:  
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-committee>

**Сингапур Улс**

- Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах тухай хууль: (Accounting and Corporate Regulatory Authority Act, 2004)-ийн 1 бүлгийн 2.1 дэх зүйл  
<https://sso.agc.gov.sg/Act/ACRAA2004>
- Сингапур Улсын Аж ахуйн нэгжийн бүртгэлийн тухай хууль:  
<https://sso.agc.gov.sg/Act-Rev/32/Published/20040731?DocDate=20040731>
- Банкны тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/BA1970>
- Барилгын хяналтын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/BCA1989>
- Даатгалын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/IA1966>
- Цахилгаан, эрчим хүчний тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/EA2001>
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/HPA2007>
- Согтууруулах ундааны хяналтын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/LCSCA2015>
- Тамхины тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993>
- Tobacco (Control of Advertisements and Sale) (Licensing) Regulations 2017:  
<https://sso.agc.gov.sg/SL/TCASA1993-S763-2017?DocDate=20211230>
- Тамхины тухай хуулийн дагалдах хууль тогтоомж:  
<https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993?ViewType=SI>
- Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах агентлаг:  
<https://www.acra.gov.sg>
- <https://www.gobusiness.gov.sg>
- Засгийн газрын агентлаг Анагаах ухааны газар: <https://www.hsa.gov.sg/tobacco-regulation/>

**ТУХН-ийн гишүүн зарим улсууд**

- Закон Азербайджани О лицензиях и разрешениях от 15.03.2016 года:  
[https://base.spinform.ru/show\\_doc.fwx?rgn=85079](https://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=85079)
- Закон Армении О Лицензировании от 30.05.2001 года:  
<https://www.arlis.am/DocumentView.aspx?docID=67471>

- Закон Грузии О лицензиях и разрешениях, 24.06.2005 года:  
<https://matsne.gov.ge/ru/document/view/26824?publication=87>
- Закон Казахстан “О разрешениях и уведомлениях” от 16.05.2014 года:  
[https://online.zakon.kz/Document/?doc\\_id=31548200&pos=3;-109#pos=3;-109](https://online.zakon.kz/Document/?doc_id=31548200&pos=3;-109#pos=3;-109)
- Закон Кыргызии О лицензионно-разрешительной системе в Кыргызской Республике от 19.10.2013 года № 195: <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/205058>
- Закон РФ О лицензировании отдельных видов деятельности. Принят ГД 22.04.2011 года. Одобрен СФ 27.04.2011 года:  
<http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102147413>
- Закон Узбекистан О лицензировании, разрешительных и уведомительных процедурах. Принят Законодательной палатой 5 марта 2021 года. Одобрен Сенатом 23.04.2021 года:  
<https://www.lex.uz/acts/5511900?ONDATE=15.07.2021%2000#5518717>
- Л.В.Стандзюнь. Система федерального законодательства о лицензировании: проблемы и перспективы законодательного регулирования. Актуальные проблемы российского права. 2018. No 12 (97): <https://cyberleninka.ru/>

УИН.МН  
СУДАЛГААНЫ САН